



ЭЕРЭГ  
НӨЛӨӨ  
БҮТЭЭСЭН **5** ЖИЛ



**Энэхүү тайланг Лоринэт Сан  
дараах үндсэн зорилгоор бүтээв.**

**Үүнд:**

Сан үүсгэн байгуулагдсанаас хойших 5 жилийн  
үйл ажиллагааны үр дүнг нэгтгэн дүгнэх,

Санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрүүдийнхээ  
сайн туршлагыг хуваалцах,

Нийгмийн сайн сайхны төлөөх үйлсэд нэгдэх сонирхолтой  
хэн бүхнийг бидэнтэй хамтран ажиллахыг уриалах.

## ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧДЫН МЭНДЧИЛГЭЭ



“Сайхан сэтгэлийн хандив тусламж нь бусдад зүгээр л өгөөд орхих гэхээсээ илүүтэй аливаа асуудлыг шийдвэрлэхэд шинэлэг арга аргачлалыг нэвтрүүлэх замаар, зорилтот бүлгийн иргэдийнхээ бие даан амьдрах чадварыг бэхжүүлэхэд чиглэх ёстой. Нийгмийн сайн сайхны төлөөх үйлсийг ийнхүү стратегитайгаар хэрэгжүүлж, эцэст нь таны туслалцаа шаардлагагүй болох үед амжилтаа бодитоор хэмжих нөхцөл үүснэ.”

**Лоринэт Сангийн хамтран үүсгэн байгуулагч  
Пьер Лоринэт**

“Бидний хувьд үр хүүхдүүдээ бусдын төлөө санаа тавьдаг, туслалцаа хэрэгтэй хэн нэгэнд хүнлэг, энэрэнгүй ханддаг бие хүн болгон өсгөн хүмүүжүүлж, үүнд үлгэрлэх нь нэн чухал юм.”

**Лоринэт Сангийн хамтран үүсгэн байгуулагч  
Болор Лоринэт**

Бид 5 жилийн өмнө Монгол Улсын амьжиргааны түвшнээс доогуур орлоготой айл өрхийн хүүхэд, залууст туслах, тэднийг дэмжих зорилгоор гэр бүлийн сангаа байгуулсан. Бага насны хүүхдийн асаргаа халамж, боловсрол болон залуучуудын хөдөлмөр эрхлэлт хамгийн их дэмжлэг шаардлагатай тулгамдсан асуудлууд хэмээн үзэж, бодитоор шийдэж чадна гэдэгтээ итгэлтэй байсан тул энэ чиглэлүүдэд хөрөнгө оруулахаар шийдсэн билээ.

Эргээд харахад сангийн маань эхний жилүүдийн үйл ажиллагаа хамтран ажиллагч байгууллагууд болон ажилтнуудын маань хүчин чармайлтын үр дүнд амжилттай хэрэгжиж, олон эерэг үр дүнг бий болгосонд маш их бахархалтай байна. Нэг талаар бид олон хүүхэд, залуус, гэр бүлүүдийн амьдралд “шууд утгаар нь” эергээр нөлөөлж гэрэл гэгээ авчирсан бол, нөгөөтээгүүр үндсэн чиглэлүүдийнхээ хүрээнд урт хугацааны, тогтолцооны өөрчлөлтөд чиглэсэн “системийн” түвшний үр нөлөөг бий болгохын төлөө ажиллалаа. Энэхүү тайлангаараа бид өнгөрсөн хугацаанд олж авсан сургамжууд болон бий болгосон ололт амжилтуудаа уншигч та бүхэнтэй хуваалцаж байна.

Бид анхнаасаа сониуч байж, эрсдэлтэй гэж хэлж болох хөрөнгө оруулалтуудыг хийн, төсөл хөтөлбөр хэрэгжүүлж буй орон нутагтаа бодит үр дүнг бий болгох чиглэлд ажиллаж ирсэн. Мөн хамтрагч байгууллагууд, зорилтот бүлгийн иргэд, дотоодын болон олон улсын ижил төстэй сангуудаас байнга суралцсаар байна. Энэ тайлангаар бид дан ганц амжилт бүтээлээ хуваалцахаас гадна цаашид ч үргэлжлүүлэн дэмжих, шийдвэрлэх шаардлагатай байгаа асуудлуудыг уншигч таны анхаарлын төвд авчрахыг зорьсон юм. Мөн сангийнхаа үйл ажиллагаагаар дамжуулан гол оролцогч талуудыг татан оролцуулж, хамтын ажиллагаагаа улам өргөжүүлж, улмаар Монгол Улсад урт хугацааны, нийгмийн эерэг нөлөөллийг бий болгоход чиглэсэн олон талт хамтын ажиллагааг бэхжүүлж чадна гэдэгт итгэж байна.

Ирэх жилүүдэд бид улам их итгэл найдвар, урам зоригтойгоор ажиллах болно. Бидэнтэй нэгдэж, хүүхэд, залуусын ирээдүйн сайн сайхны төлөө хувь нэмрээ оруулахаар хүсэж буй хэн бүхэнтэй өөрсдийн мэдлэг туршлагаа хуваалцаж, нөөцөө нэгтгэн хамтран ажиллахад бэлэн байна.

Болор Лоринэт

Пьер Лоринэт

# МАНАЙ ХАМТ ОЛОН

## Удирдах зөвлөлийн гишүүд



**Пьер Лоринэт**  
Хамтран үүсгэн байгуулагч,  
Удирдах зөвлөлийн дарга



**Болор Лоринэт**  
Хамтран үүсгэн  
байгуулагч



**Наталье Морал**  
Clima Now-ын Хамтран үүсгэн  
байгуулагч, Гүйцэтгэх захирал



**Жан Мари Формиж**  
Bayard SA-ын Удирдах  
зөвлөлийн дарга

## Менежментийн баг



**Сүмит Жоши**  
Олон улсын үйл ажиллагаа  
хариуцсан захирал



**Батсайханы  
Тамир**  
Монгол дахь үйл ажиллагаа  
хариуцсан захирал



**Лувсандарын  
Пүрэвцэнгэл**  
Хөтөлбөр мэдлэгийн менежер



**Оюунтөгсийн  
Дашноров**  
Мэдээлэл харилцааны ажилтан




## Зөвлөхүүд






**Дүгэрээгийн Заяасайхан**  
Швейцарын хөгжлийн  
агентлагийн Үндэсний  
хөтөлбөрийн ахлах  
зохицуулагч



**Жессика Хжарранд**  
Porticus-ын Бага насны  
хүүхдийн хөгжлийн олон улсын  
хөтөлбөрийн менежер – Онцгой  
байдлын үеийн боловсрол





**9** ЛОРИНЭТ САН: ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛҮҮД

- 13 Яагаад Монгол Улс гэж?
- 17 Хүүхэд залуусын төлөө

**23** ОНЦЛОХ ҮР ДҮНГҮҮД

- 26 Төсөл хөтөлбөрийн шууд үр нөлөө: Голлох тоон үзүүлэлтүүд
- 28 Системийн түвшний үр нөлөө: Голлох амжилтууд

**31** ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН ШУУД ҮР НӨЛӨӨ

- 32 Вьетнам Улсад бага насны хүүхдийн асаргаа халамж, хөгжлийн асуудлыг шийдвэрлэсэн нь
- 36 Монгол эцэг эх, асран хамгаалагч нарын хүүхдээ асарч халамжлах ур чадварыг нэмэгдүүлсэн нь
- 40 Монгол Улсад номоор дамжуулан бага насны хүүхдийн хөгжил, боловсролыг дэмжих нь
- 44 Вьетнам Улсын зорилтот бүлгийн залуучуудад ур чадвар эзэмшүүлж, тогтвортой хөдөлмөр эрхлэлттэй болгосон нь
- 48 Вьетнам Улсын үндэстний цөөнх залуу эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг бэхжүүлсэн нь
- 52 Монгол залуучуудыг боловсролоос хөдөлмөр эрхлэлт рүү шилжихэд дэмжлэг үзүүлсэн нь
- 56 Монгол Улсад гэр хорооллын залуу гэр бүлүүдийн өрхийн амьжиргааг дэмжсэн нь
- 61 Ковид-19 цар тахлын үед хүмүүнлэгийн тусламж үзүүлсэн нь

**63** СИСТЕМИЙН ТҮВШНИЙ ҮР НӨЛӨӨ: ЯВЦЫН ҮР ДҮН

- 64 Монголын бага насны хүүхдийн хөгжлийн сүлжээг байгуулахад манлайлан оролцсон нь
- 65 Монгол Улсын бодлого төлөвлөлтөд олон улсын сайн туршлагыг хуваалцсан нь
- 66 Хамтрагч байгууллагуудынхаа чадавхыг бэхжүүлж, тогтвортой хөгжилд тэмүүлэх нь
- 68 Хөтөлбөрүүдийнхээ цар хүрээг тэлэхийн тулд төртэй хамтран ажиллах нь

**71** МЭДЛЭГ БҮТЭЭЖ, ХУВААЛЦСАН НЬ

**79** САНХҮҮЖИЛТИЙН ШИНЭЛЭГ АРГА ХЭЛБЭРҮҮДИЙГ АШИГЛАХ НЬ

- 82 Дэлхийн хамгийн анхны Нийгмийн үр өгөөжийн баталгаа – Сингапур Улс
- 84 Хөгжиж буй гарааны бизнесүүдийг дэмжих зээлийн санхүүжилт

**87** БИДНИЙ ЦААШДЫН ТӨЛӨВЛӨГӨӨ



1

## ЛОРИНЭТ САН: ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛҮҮД



Лоринэт Сан нь туслалцаа, дэмжлэг шаардлагатай байгаа Монгол Улсын хүүхэд залуус, гэр бүлүүдийн амьдралд тогтвортой, эерэг өөрчлөлтийг бий болгох үндсэн зорилготой. Энэ хүрээнд бага насны хүүхдийн асаргаа халамж, боловсрол болон залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг үйл ажиллагааныхаа үндсэн чиглэл болгон ажилладаг ба энэ чиглэлийн байгууллагууд, холбогдох санал санаачилгуудыг дэмжин ажиллаж байна. Үүнд:

- **0-5 насны хүүхдүүдэд** чанартай асаргаа халамж, боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэн, тэдний насны онцлогт тохируулан суралцах боломжийг нэмэгдүүлэх;
- **15-29 насны залуучуудын** хөдөлмөр эрхлэлтийн бэлэн байдлыг сайжруулан, хөдөлмөр эрхлэлт рүү шилжихэд нь дэмжлэг үзүүлж, нийгэм эдийн засгийн хувьд бие даах чадварыг нь бэхжүүлэхийн тулд ажиллаж байна.

Сангийн үйл ажиллагаа нь бага насны хүүхэд залуус руу чиглэхээс гадна холбогдох гол оролцогч талууд буюу тэдний гэр бүл, эцэг эх, асран хамгаалагчид, үйлчилгээ үзүүлэгчид болон экосистемийн бусад оролцогч нарт хүрч ажилладаг.

Зүүн Өмнөд Азийн сайн туршлагаас суралцах, эерэг үр нөлөө ихтэй төсөл хөтөлбөрүүдийг дэмжих болон тус бүс нутгийн голлох оролцогч талуудтай харилцаа холбоо тогтоох замаар сангийнхаа үйл ажиллагааг бэхжүүлэх зорилготой ажиллаж байна. Өөрөөр хэлбэл, бид олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагуудтай хамтын ажиллагаа өрнүүлж, тэдний мэдлэг туршлагыг судалж, нотолгоонд суурилсан арга аргачлалуудаас нь суралцдаг. Ингэснээр Монгол Улсад хамгийн үр нөлөө ихтэй төсөл хөтөлбөрүүдийг нэвтрүүлэх, тэдгээр арга аргачлал, туршлагыг дотоодын нөхцөлд тохируулан ашиглах боломжтой гэдэгт бид итгэдэг билээ.

## ЯАГААД МОНГОЛ УЛС ГЭЖ?



Лоринэт Сангийн хамтран үүсгэн байгуулагч Болор Лоринэт нь 1980-аад онд Монгол Улсад төрж өссөн. Тэрээр эх орныхоо шилжилтийн үеийн нийгэм эдийн засгийн эмзэг байдлыг өөрийн нүдээр үзсэн учраас Монгол Улс иргэн бүртээ ээлтэй, хүртээмжтэй хөгжих үйлсэд хувь нэмрээ оруулахыг хүссэн юм. Сүүлийн 30 жилийн хугацаанд Монгол Улс социализмаас ардчилсан нийгэмд шилжиж, ядуурлыг бууруулах, иргэдийн амьдралын чанарыг сайжруулахад тодорхой хэмжээнд ахиц дэвшил гаргасан боловч эдийн засгийн өсөлт нь тогтвортой, хүн бүрд хүртээмжтэй байж чадаагүй. Тиймээс Монгол Улсын амьжиргааны түвшнээс доогуур орлоготой айл өрхүүд, хүүхэд залуусын амьдралд тогтвортой, урт хугацааны эерэг өөрчлөлтийг авчрах зорилгоор Пьер болон Болор Лоринэт нар гэр бүлийн сангаа байгуулсан билээ.

2017 оноос Лоринэт Сан Улаанбаатар хотын гэр хороололд амьдран суугаа иргэдийн амьдралд нийгэм, эдийн засгийн эерэг үр нөлөөг бий болгох зорилгоор үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Гэр хорооллын бүсэд нэн тэргүүнд тулгамдаж буй асуудлуудыг цогцоор нь ойлгож мэдэх судалгааны ажлыг зохион байгуулсан. Ийнхүү судалгааны үр дүнд үндэслэн үйл ажиллагааны үндсэн чиглэлүүд болох Бага насны хүүхдийн асаргаа халамж, боловсрол болон Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн асуудлууд дээр төвлөрөн ажиллахаар шийдсэн юм. Бид өнгөрсөн хугацаанд олон талын оролцогч талуудтай хамтран, төсөл хөтөлбөр дэмжин ажиллах явцдаа гэр хороололд амьдран суугаа иргэдийн нийгмийн асуудлуудыг илүү гүнзгий ойлгож, ямар арга аргачлалаар хэрхэн шийдвэрлэх талаар туршлагаа гүнзгийрүүлсээр байна.





Монгол Улс нь БНХАУ болон ОХУ-ын дунд орших далайд гарцгүй орон бөгөөд Баруун Европтой тэнцэх хэмжээний газар нутагтай хэдий ч, ердөө 3.4 сая хүн амтай улс юм. Эрс тэс уур амьсгалтай бөгөөд нүүдлийн соёл иргэншил, орчин цагийн хөгжил дэвшил зэрэгцэн оршдог онцлогтой. Нийслэл Улаанбаатар хотод нийт хүн амын бараг тэн хагас нь амьдардаг бөгөөд нөгөө хэсэг нь өргөн уудам нутагтаа жижиг суурин газруудад тархан суурьшдаг. Тиймээс нийслэл хотын сайн сайхан байдал нь улсын сайн сайхан байдалд шууд нөлөөлдөг гэхэд хилсдэхгүй.

Харин Улаанбаатар хотын хүн амын 60 орчим хувь нь гэр хорооллын бүсэд амьдардаг. Харамсалтай нь, хотжилт тэнцвэргүй явагдсаны улмаас нийгэм эдийн засгийн хөгжлийн ялгаатай байдал гэр хороололд үүссэнийг тод харж болно. Тухайлбал дэд бүтэц хангалтгүй байдгаас гадна чанартай боловсрол эзэмших болон хөдөлмөр эрхлэх боломж харьцангуй хомс байдаг. Иймд гэр хороололд амьдран суугаа иргэдийг нийгэм, эдийн засаг, хүний хөгжлийн боломжуудаар хангах нь нэн чухал юм.

## ХҮҮХЭД ЗАЛУУСЫН ТӨЛӨӨ

### Бага насны хүүхдийн асаргаа халамж, боловсролд хөрөнгө оруулах нь

Хүүхэд эхээс мэндэлсэн цагаас эхлэн тав хүртэлх насны үе нь тархины хөгжил эрчимтэй явагддаг төдийгүй цаашдын өсөлт хөгжил, ирээдүйд амжилттай суралцах, сайн сайхан амьдрах үндэс суурь нь тавигддаг чухал үе болохыг олон улсын судалгаанууд нотолсоор байна. Аливаа хүн бага насандаа эрүүл саруул, аюулгүй орчинд өсөж торнин, сурч хөгжиж чадвал, өөрийн нөөц бололцоогоо бүрэн дайчилж, улмаар нийгэм, эдийн засаг, соёлын харилцаандаа амжилт гаргана гэж үздэг. Сүүлийн жилүүдэд бага насны хүүхдийн асаргаа халамж, боловсролын асуудалд анхаарал хандуулах нь нэмэгдэж байгаа хэдий ч энэ чиглэлийн үйлчилгээний чанар, хүртээмж хангалтгүй, ялангуяа зорилтот бүлгийн өрхийн хүүхдүүдэд дутмаг хэвээр байна.

Бага насны хүүхдийн асаргаа халамж, боловсролд хөрөнгө оруулах нь хамгийн үр ашигтай буюу урт хугацаанд нийгмийн зардлыг бууруулж, эдийн засгийн өсөлтийг дэмждэг нь батлагдсан байдаг. Гэсэн хэдий ч, боловсрол руу чиглэсэн олон улсын хандив тусламжийн маш бага хувь нь сургуулийн өмнөх боловсролын салбарт олгогддог.

Лоринэт Сан нь Бага насны хүүхдийн асаргаа халамж, боловсролд хөрөнгө оруулснаар тухайн хүүхдүүдийн сайн сайхан байдалд эерэг нөлөө авчраад зогсохгүй, улс орны хөгжилд тэдний оруулах хувь нэмрийг нэмэгдүүлнэ гэж үздэг. Тийм ч учраас бид Монгол Улсад нэн тэргүүнд тусламж дэмжлэг шаардлагатай байгаа бага насны хүүхдүүдэд хөрөнгө оруулж байна.





## Залуучуудын хөдөлмөр эрхлэлтэд хөрөнгө оруулах нь

Хүн төрөлхтний түүхэн дэх хамгийн олон залуу хүн амьдарч байгаа өнөө цаг үед, ихэнх хөгжиж буй орнуудын хувьд залуучуудын ажилгүйдэл хамгийн тулгамдсан асуудлын нэгт тооцогдож байна. Дэлхийн Банкны мэдээлснээр 2021 онд монгол залуучуудын 17.2 хувь нь хөдөлмөр эрхлээгүй, мөн боловсрол сургалтад хамрагдаагүй байжээ. Хөдөлмөрийн зах зээлд нэвтрэх нь эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд төдийгүй туршлага, ур чадвар багатай залуучууд зэрэг нийгмийн бүлгүүдийн хувьд илүү бэрхшээлтэй байдаг. Үүний улмаас залуучууд ихэвчлэн цалин хөлс багатай, ажлын орчин сайнгүй, албан бус салбарт ажилд ордог байна.

Тогтвортой орлогогүйн улмаас залуучууд ядууралд өртөж, хөдөлмөр эрхлэхгүй удах тусам нийгмээс тусгаарлагдаж, сэтгэл санаа, бие махбодын эрүүл мэндийн хувьд сөрөг үр дагавруудтай тулгардаг нь нотлогдсон байдаг. Залуучуудын ажилгүйдэл, эдийн засгийн идэвхгүй байдал өндөр байх нь тухайн хувь хүн, тэдний гэр бүлд их хэмжээний нийгэм эдийн засгийн зардлыг бий болгож байдаг ба улс орны хувьд татварын орлогыг бууруулж, нийгмийн хамгаалал, халамжийн зардлыг нэмэгдүүлдэг. Улмаар залуучуудын ажилгүйдэл тухайн улсын төдийгүй дэлхийн хөгжил цэцэглэлт, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлдөг байна.

Энэ ч утгаараа, залуучуудад боловсролоос хөдөлмөр эрхлэлтэд шилжих үед дэмжлэг үзүүлэх чухал ач холбогдлыг ухамсарлан, Лоринэт Сан нь Монгол Улсын нэн тэргүүнд тусламж дэмжлэг шаардлагатай залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ажиллаж байна.



Өнгөрсөн 5 жилийн хугацаанд Лоринэт Сан дараах хоёр чиглэлд нийгмийн үр нөлөө (social impact) бий болгохын төлөө ажиллалаа. Үүнд:

- Бага насны хүүхдийн асаргаа халамж, боловсрол болон Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэнээр гарах **шууд үр нөлөө**
- Үндсэн чиглэлүүдийнхээ хүрээнд холбогдох мэдлэг, мэдээллийг боловсруулан түгээж, олон талт хамтын ажиллагааг бэхжүүлж, урт хугацааны тогтвортой үр өгөөж авчирдаг сайн туршлагуудыг нэвтрүүлснээр бий болгох **системийн түвшний үр нөлөө**

Лоринэт Сан нь нийгмийн үр нөлөө бодитоор авчирч байгаа шинэлэг төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагуудад санхүүгийн болон санхүүгийн бус дэмжлэг үзүүлдэг. Үүнээс гадна нийгмийн нөлөөллийн хөрөнгө оруулалт (impact investment) зэрэг бусад төрлийн санхүүжилтийн шинэлэг арга хэрэгслүүдийг ашиглан зорилтот бүлгийн иргэдийн амьдралд эерэг өөрчлөлт авчрахын төлөө ажиллаж байна.

Бид энэ хугацаанд үндсэн чиглэлүүдийнхээ хүрээнд илүү гүнзгийрүүлэн судлах, суралцах болон төсөл хөтөлбөрийнхөө үр нөлөөг бодитоор хэмжиж үнэлэх ажилд өөрсдийн санхүүгийн болон хүний нөөцөө тусгайлан зориулж, “үр дүнд төвлөрсөн” болон “тасралтгүй суралцах” үйл явцыг эрхэмлэдэг байгууллага байсаар ирсэн. Тэр ч утгаараа, хэрэгцээ тодорхойлох судалгаанаас эхлээд Зүүн Өмнөд Азийн туршлагаас суралцаж, улмаар олон улсын түвшинд амжилттай хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн арга, аргачлалын талаар нарийвчлан ойлгох судалгааны ажлуудыг хийж гүйцэтгээд байна.

Аливаа урт хугацааны, тогтвортой өөрчлөлт, эерэг үр нөлөөг бий болгох үйл явц нь бодлого боловсруулагчид, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгч нар, эрдэмтэн судлаачид, хувийн хэвшил болон олон нийт гээд олон талын оролцогч талуудын хамтын ажиллагааны үр дүнд бий болно гэдэгт бид итгэдэг. Учир нь бид хамтрагч байгууллагууд, дэмжигчид, түншүүдийнхээ чин сэтгэлийн хүчин чармайлтын үр дүнд хамтын нөлөөллийг бий болгодог билээ.

Мөн бидэн шиг нийгмийн сайн сайхны төлөө ажилладаг гэр бүлийн сангууд, бусад хандивлагч байгууллагуудын хувь нэмэр чухал үүрэгтэй бөгөөд “Нөлөөллийн төлөөх түншлэл, хамтын ажиллагаа” нь Лоринэт Сангийн үндсэн үзэл баримтлалын нэн чухал хэсэг байсаар байх болно.



## ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ (ГРАНТ)

**44,965**

санхүүжилтийн  
үр шимийг  
хүртсэн нийт  
хүний тоо<sup>1</sup>

**2.1 сая ам  
доллар**

нийт санхүүжилтийн  
дүн

**63%**

Бага насны хүүхдийн асаргаа  
халамж, боловсрол

**27%**

Залуучуудын  
хөдөлмөр эрхлэлт

**10%**

Бусад

**79%**

Монгол

**21%**

Зүүн Өмнөд Ази



<sup>1</sup> Лоринэт Сан зарим төсөл хөтөлбөрүүдээ бүрэн санхүүжүүлсэн ба зарим төсөл хөтөлбөрүүдийн хувьд бусад санхүүжүүлэгч нартай хамтран ажилласан. Энэ тайланд ойлгомжтой байлгах үүднээс бид бүх төсөл хөтөлбөрийнхөө нийт үр дүнг нэгтгэн тайлагнасан болно.

НИЙГМИЙН НӨЛӨӨЛЛИЙН  
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ  
(IMPACT INVESTMENT)

**165,000**  
хүнд хүрсэн

**3.5 сая ам.доллар**  
нийт санхүүжилтийн дүн

# ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН ШУУД ҮР НӨЛӨӨ: ГОЛЛОХ ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Бага насны хүүхдийн асаргаа халамж, боловсрол

Залуучуудын хөдөлмөр эрхлэлт

**26,713**

бага насны хүүхдийн чанартай асаргаа халамж, эрт үеийн боловсролд хамруулсан 0-5 настай хүүхдийн тоо<sup>2</sup>

**1,238**

чадавхжуулах сургалтад хамрагдсан эцэг эх, асран хамгаалагчдын тоо

**58%**

ур чадвар нь нэмэгдсэн хэмээн мэдүүлсэн эцэг эх, асран хамгаалагчдын эзлэх хувь

**1,656**

чадавхжуулах сургалтад хамрагдсан бага насны хүүхдийн асаргаа халамж, эрт үеийн боловсролын үйлчилгээ үзүүлэгчдийн тоо

**3,890**

хөдөлмөр эрхлэх болон өрхийн амьжиргаагаа дээшлүүлэхэд шаардлагатай ур чадваруудыг олгох сургалтад хамрагдсан залуучуудын тоо<sup>3</sup>

**79%**

сургалтад хамрагдаад хөдөлмөр эрхлэлт рүү шилжсэн залуучуудын эзлэх хувь

**81%**

сургалтад хамрагдсанаар орлого эсвэл амьдралын чанар нь сайжирсан хэмээн мэдүүлсэн залуучуудын эзлэх хувь

**222**

ажиллах хүчний чадавхыг бэхжүүлэхэд хамтран ажилласан ажил олгогч, төрийн байгууллагын албан хаагчдын тоо



<sup>2</sup> Эцэг эх, асран хамгаалагч нь сургалтад хамрагдсан, мөн хүүхэд хөгжил боловсролын төвөөр дамжуулан үр шим хүртсэн хүүхдүүдийн тоог нэгтгэн тооцов.

<sup>3</sup> Англи хэл, амьдрах ухаан, техник мэргэжлийн, бизнес эрхлэх зэрэг ур чадварын сургалтуудад хамрагдсан залуучууд болон өрхийн амьжиргааг нь дэмжсэн гэр бүлүүдийн тоог хамтатган тооцов.

## СИСТЕМИЙН ТҮВШНИЙ ҮР НӨЛӨӨ: ГОЛЛОХ АМЖИЛТУУД



Монгол Улсын залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн болон бага насны хүүхдийн асаргаа халамж, боловсролын асуудлуудын хүрээнд цогц судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэж, энэ чиглэлийн статистик, нарийвчилсан шинжилгээ, дүгнэлтүүдийг танилцуулснаар холбогдох оролцогч талуудын хөрөнгө оруулалтын болон бүх шатны шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүллээ



Монгол Улсад бага насны хүүхдийн хөгжлийн салбарын гол оролцогч талуудын мэдлэг, туршлагаа солилцох, хамтын ажиллагаа өрнүүлэх зорилго бүхий "Монголын бага насны хүүхдийн хөгжлийн сүлжээ"-г анхлан байгуулахад манлайлан оролцлоо



Монгол Улсын Бага насны хүүхдийн хөгжлийн бодлого боловсруулах үйл явцад дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. 2022 онд 0-3 насны хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчид чиглэсэн "Нялх, балчир насны хүүхдийн хөгжлийг дэмжих хөтөлбөр" батлагдсан бол "Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээ" бодлогын баримт бичиг мөн Засгийн газарт өргөн баригдаж, хэлэлцэгдэж байна



Вьетнам Улсад дэмжин ажилласан Уанскай байгууллагын гэрийн орчинд хувиараа хүүхэд харах үйлчилгээ үзүүлэгчдийн чадавхыг сайжруулах сургалтын хөтөлбөрийг Засгийн газар нь дэмжиж, үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхээр боллоо



Вьетнам Улсад хамтран ажилладаг REACH байгууллагын дэргэдэх хоёр нийгмийн бизнес (social enterprise)-ийг байгуулахад дэмжлэг үзүүлж, тус байгууллагын санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүллээ. Энэхүү бизнесүүд нь дараагийн 3 жилийн хугацаанд ашиг орлогоосоо REACH-ийн хийж буй нийгмийн сайн сайхны үйлсэд нэмэрлэх юм



Дэлхийд хамгийн анхны Нийгмийн үр өгөөжийн баталгаа (Social Impact Guarantee) бүхий санхүүжилтийн механизмийг нэвтрүүлж, улмаар Сингапур Улсад эрсдэлт бүлгийн залуучуудын хөдөлмөр эрхлэлт болон боловсрол, сургалтад хамрагдалтын түвшнийг 59 хувиас 77 хувь хүртэл нэмэгдүүллээ





## ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН ШУУД ҮР НӨЛӨӨ



Сүүлийн 5 жилийн хугацаанд Лоринэт Сан олон төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэн ажилласан бөгөөд үүгээрээ дамжуулан тодорхой асуудлуудыг шийдэж, улмаар төсөл хөтөлбөрийн оролцогч нартаа эерэг өөрчлөлтийг авчрахыг хичээн ажиллалаа. Энэхүү туршлага нь бидний хувьд үнэ цэнтэй сургамж болж, үйл ажиллагаагаа улам төгөлдөржүүлэх боломжийг олгосон юм.

Дараах бүлэгт бидний санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрүүдийн тухай ерөнхий мэдээлэл, голлох үр дүнгүүд болон амжилтын түүхүүдээ хуваалцаж байна.

# ВЬЕТНАМ УЛСАД БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН АСАРГАА ХАЛАМЖ, ХӨГЖЛИЙН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН НЬ

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА:  
УАНСКАЙ ВЬЕТНАМ, 2019-2022



Уанскай нь 1998 онд байгуулагдсан ашгийн бус байгууллага бөгөөд дэлхий даяар эрсдэлтэй нөхцөлд байгаа хүүхдүүд ирээдүйдээ сайн сайхан амьдрах боломжийг нэмэгдүүлэхийн тулд бага насны хүүхдийн эрт үеийн боловсрол, хүүхдээ ойлгон хөгжүүлэхийн ач холбогдлыг тэдний асран хамгаалагч, эргэн тойрны хүмүүст ойлгуулдаг, практик арга аргачлалыг зааж сургадаг байгууллага юм.

## ШИЙДВЭРЛЭХЭЭР ЗОРЬСОН АСУУДАЛ:

Өнөө цагийн Вьетнам Улс цэцэглэн хөгжиж байгаа ч эрүүл мэнд, боловсрол, орон байр, хүүхэд хамгааллын тулгамдсан асуудлууд зэрэгцэн оршдог. Орчин цаг нь хөгжил дэвшлийг тодорхой хэмжээнд авчирсан хэдий ч нийт вьетнамчуудын гуравны нэг нь “нэн ядуу” хэвээр байгаа бөгөөд хүүхдүүд ядуурал, хүний наймаанд өртөх эрсдэлтэй байна. Үндэсний хэмжээнд үйлдвэрийн ажилчдын 1.2 сая орчим хүүхэд үйлдвэрийн бүс, түүний эргэн тойронд нь амьдарч байна. Эдгээр гэр бүлүүдийн хувьд ажлын цагаар хүүхдээ харуулах чанартай үйлчилгээ болон улсын цэцэрлэгт хүүхдээ хамруулах боломж хомс учраас бага насны хүүхдүүд нь холбогдох стандартад нийцээгүй асаргаа халамжийг авч байна. Гэрийн орчинд хувиараа хүүхэд харах үйлчилгээ үзүүлэгч нар (home-based care providers) байдаг ч ихэнхдээ бага насны хүүхдийн боловсрол хөгжлийн талаар мэдлэг хангалтгүй, албан сургалтад хамрагдаагүй байдаг.

## БИДНИЙ ШИЙДЭЛ:

Лоринэт Сан бусад санхүүжүүлэгч нарын хамтаар Вьетнам Улсад үйлдвэрлэлийн бүсийн эргэн тойронд амьдарч байгаа бага насны хүүхдүүдийн асаргаа халамж, хөгжлийн асуудлыг шийдвэрлэх зорилготой Уанскайн **Үйлдвэрийн Загварыг** дэмжсэн. Вьетнам Улсын Боловсрол сургалтын яам (БСЯ) энэхүү загварыг 10 муждаа нэвтрүүлэхээр шийдсэн нь үйлдвэрийн ажилчдын ойролцоогоор 800,000 хүүхдэд хүрч ажиллахаар төлөвлөөд байна. Цар хүрээг нь ийнхүү тэлэхийн өмнө Уанскай энэхүү загвараа дараах үндсэн гурван зорилготойгоор Дананг мужид туршиж үзсэн.

- Хоа Канн (Hoа Khanh) үйлдвэрийн бүсэд Уанскайн **Бага Насны Хүүхдийн Сургалтын Загвар Төвийг** байгуулж, үйлдвэрийн ажилчдын хүүхдүүдэд аюулгүй асаргаа халамж авч болох орчныг бүрдүүлэх
- Загвар төвийн үйл ажиллагаанд тулгуурлан, гэрийн орчинд хувиараа хүүхэд харах үйлчилгээ үзүүлэгч нарыг бэлтгэж, тэднээр дамжуулан Дананг мужийн 16,000 орчим бага насны хүүхдэд хүрч ажиллах
- Дананг мужийн туршилтын төсөлд үндэслэн, Вьетнам Улсын хэмжээнд үйлдвэрийн ажилчдын хүүхдүүдийг асарч халамжлах үндэсний загвар хөтөлбөрийг боловсруулах.



“ Сургалтын хөтөлбөрөөр хүүхдүүдэд мэдлэг олгохоос гадна, тэдэнд тав тухтай нөхцлийг бүрдүүлж, аюулгүй орчинд, хүүхдүүдийн өөрсдийнх нь оролцоотойгоор сургаж хүмүүжүүлэх нь чухал гэдгийг маш сайн ойлгосон. – Гэрийн орчинд хувиараа хүүхэд харах үйлчилгээ үзүүлэгч ”

## ГОЛЛОХ ҮР ДҮНГҮҮД:

Бага насны хүүхдийн сургалтын загвар төвөөр дамжуулан **564 бага насны хүүхдэд** аюулгүй орчинд асран халамжлуулах, сурч хөгжих боломжийг олгосон

20 гаруй жилийн турш хөгжүүлж, хэрэгжүүлсэн хөтөлбөрийн агуулгаа Вьетнам хүүхдүүдийн онцлогт тохируулан **орон нутгийн багш, ажилтнуудыг сурган, ажиллуулсан**

Туршилтын төслийн хүрээнд **948 гэрийн орчинд хувиараа хүүхэд харах үйлчилгээ үзүүлэгч нарыг сургаж**, тэд өөрсдийн төвүүд дээрээ 23,000 орчим бага насны хүүхдэд чанартай асаргаа халамж үзүүлж байна

Уанскай “1GiaDinhLon” (1BigFamily) нэртэй **цахим сургалтын платформыг** бүтээж; нийт 1,186 гэрийн орчинд хувиараа хүүхэд харах үйлчилгээ үзүүлэгч нарыг тус платформдоо нэгтгээд байна

**242 эцэг эх, асран хамгаалагчийг** гэрийн нөхцөлд хүүхдийнхээ хөгжлийг дэмжих сургалтад хамруулан, чадавхжуулсан

## НИЙГМИЙН САЙН САЙХНЫ ТӨЛӨӨХ ҮЙЛСЭД ХАМТАРСАН НЬ

Энэхүү туршилтын төслийн санаа, цар хүрээг нь нэмэгдүүлэх боломж зэрэг нь Лоринэт Сангийн хувьд маш гайхалтай санагдсан учир бид ижил төстэй зорилго бүхий санхүүжүүлэгч нарыг татан оролцуулахыг хүссэн юм. Улмаар бид Сингапурт төвтэй Octava Foundation-тай хамтын ажиллагааг амжилттай өрнүүлж чадсан ба энэхүү туршилтын төслийг хамтран санхүүжүүлсэн.



**HARVARD T.H. CHAN**  
SCHOOL OF PUBLIC HEALTH

### Уанскайн сургалтын хөтөлбөрт хийсэн Харвардын чанарын үнэлгээ

Вьетнамын Орон нутгийн хөгжлийн сургалт, судалгааны төв (Research and Training Centre for Community Development) болон Харвардын Ти Эйч Чан нийгмийн эрүүл мэндийн сургуулийн (Harvard T.H. Chan School of Public Health) судлаачид хамтран 2019-2020 онд Уанскайн сургалтын хөтөлбөрийн чанар, үр нөлөөг судалсан. Энэ судалгаа нь:

- Азийн үйлдвэрлэлийн бүст гэрийн орчинд хувиараа хүүхэд харах үйлчилгээ үзүүлэгч нарын үйлчилгээний чанар, үр нөлөөг **анх удаа үнэлсэн**
- Өндөр хөгжилтэй орнуудаас бусад газарт хийгдсэн **хамгийн өргөн цар хүрээтэй** судалгаа болсноороо онцлогтой байв.

#### Үнэлгээний үр дүн:

- Вьетнам Улсад гэрийн орчинд хувиараа хүүхэд харах үйлчилгээг чанартай болгох маш үр дүнтэй аргачлал
- Жендэрийн тэгш байдлыг дэмжсэн арга хэмжээ
- Бусад үйлчилгээ үзүүлэгч нарт мэдлэг, ур чадвараа хуваалцах замаар хөтөлбөрийн цар хүрээг өргөтгөх бүрэн боломжтой
- Гэрийн орчинд хувиараа хүүхэд харах үйлчилгээ үзүүлэгч нарын мэргэжлийн түвшинд сургаж бэлтгэхэд чухал үүрэгтэй болохыг баталгаажуулсан

#### Үнэлгээний гол зөвлөмж:

- Тус **хөтөлбөрийн цар хүрээг тэлэх, үр нөлөөг нэмэгдүүлэхийн** тулд бусад байгууллага, санхүүжүүлэгч нартай хамтран ажиллаж, санхүүжилт татах боломжтой
- Системийн түвшинд хөтөлбөрийн үр дүнг Вьетнам Улсын БСЯ-тай хуваалцаж, **төрийн үйлчилгээнд нэвтрүүлэх** замаар цар хүрээ, үр нөлөөг нэмэгдүүлэх боломжтой
- Бага насны хүүхдийн хөгжлийн чиглэлийн олон улсын эрдэм шинжилгээний сэтгүүл, хурал зөвлөгөөн, бусад платформуудаар үнэлгээний үр дүнг сурталчилж, **нотолгоонд суурилсан мэдлэгийг хуваалцан, холбогдох талуудад таниулах** боломжтой.

### ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛД ТЭМҮҮЛЭХ НЬ

Уанскай хөтөлбөрөө Вьетнам Улсад амжилттай хэрэгжүүлсэн нь тус улсын БСЯ-тай хамтран ажиллах онцгой боломжийг бий болгосон. Тэд хамтран Уанскайн гэрийн орчинд хувиараа хүүхэд харах үйлчилгээ үзүүлэгч нарыг бэлтгэх хөтөлбөрийг дахин загварчилж, тогтолцоонд нэвтрүүлэн эхний удаад 2023 оноос 5 мужид хэрэгжүүлэхээр болсон юм.

Лоринэт Сан энэхүү хөтөлбөрийн төлөвлөлтийн үе шатны ажлыг санхүүжүүлж, Вьетнам Улс даяар Уанскайн загвар хөтөлбөр амжилттай нэвтрэхэд үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлж байна.

# МОНГОЛ ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧ НАРЫН ХҮҮХДЭЭ АСАРЧ ХАЛАМЖЛАХ УР ЧАДВАРЫГ НЭМЭГДҮҮЛСЭН НЬ

**ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА:**  
УАНСКАЙ МОНГОЛ, 2020 ОНООС ХОЙШ  
ХЭРЭГЖИЖ БАЙГАА



Олон улсын туршлагаас суралцах зарчмынхаа дагуу бид Уанскайтай Вьетнам Улсад амжилттай хамтран ажилласны дараагаар Монгол Улсад хамтын ажиллагаагаа тэлсэн юм.

## ШИЙДВЭРЛЭХЭЭР ЗОРЬСОН АСУУДАЛ:

Улаанбаатар хотын гэр хороололд амьдран суугаа бага насны хүүхдүүдэд чанартай, орлогод нийцсэн хүүхэд харах үйлчилгээний хүртээмж тун хангалтгүй байдаг. Тэд дийлэнхдээ орон зайн хувьд давчуу сууцанд амьдарч, тоглоомын талбай зэрэг хүүхдэд ээлтэй орчин хангалтгүй байна. Эдгээр олон хүчин зүйлсийн улмаас бага насны хүүхдүүдэд суралцах, тоглох, хөгжих боломж харьцангуй хомс байна. Мөн түүнчлэн эцэг эх, асран хамгаалагч нарын бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих талаарх мэдлэг ойлголт сул бөгөөд тэдэнд зориулсан энэ чиглэлийн сургалт үйл ажиллагаа хангалтгүй байна. Эдгээр тулгамдаж буй асуудлуудын улмаас бага насны хүүхдүүд хүүхэд насандаа бүрэн хөгжиж, боловсорч чадахгүй төдийгүй бие бялдар, танин мэдэхүй, хэл яриа, сэтгэл хөдлөл-нийгэмшихүйн хөгжлийн хоцрогдолтой болох эрсдэлийг дагуулж байна.

## БИДНИЙ ШИЙДЭЛ:

Лоринэт Сан Монгол Улсад Уанскайн “Илүү сайхан ирээдүйг бүтээх нь” (Building Better Futures) туршилтын төслийг дэмжиж байна. Энэхүү төсөл нь гэр хороололд оршин суудаг **бага насны хүүхдүүд чанартай хүүхэд харах үйлчилгээнд хамрагдах боломжийг нэмэгдүүлэхийн сацуу тэдний ээжүүдэд ажил хөдөлмөр эрхлэх боломжийг олгох давхар үр ашгийг бий болгох зорилгоор загварчлагдсан** юм. Туршилтын төсөл нь гэр хороололд амьдран суугаа бага насны хүүхдүүд, тэдний гэр бүлүүдэд үр дүнтэй, урт хугацаанд цар хүрээг нь тэлэх боломжтой хөтөлбөрийн загварыг бий болгож, хамтарсан байдлаар ээлжлэн хүүхдүүдээ асарч халамжлах боломжтой эсэхийг туршиж байна. Тухайлбал:

- Эцэг эх, асран хамгаалагч нарт зориулан, эрт үеийн тархины хөгжлийн ач холбогдлыг таниулах болон хүүхдээ ойлгон хөгжүүлэх (responsive caregiving) аргагүйн сургалтуудыг зохион байгуулах
- Гэр бүлүүдийн хоорондын харилцааг бэхжүүлж, хүүхдийн хөгжилд нэг нэгэндээ дэмжлэг, туслалцаа үзүүлдэг хөршийн холбоог бий болгох
- Хүүхдүүдэд зориулсан тоглох, суралцах аюулгүй орчныг нэмэгдүүлэх, хүртээмжтэй болгох
- Сургалтыг төгсөгчдөд дадлага, ажлын байр санал болгох

Лоринэт Сан бидэнд туршилтын төсөл хэрэгжүүлэх санхүүгийн дэмжлэг үзүүлэхээс гадна системийн түвшинд үр нөлөө үзүүлэхийг зорьж буй манай байгууллагын үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлэхэд шаардлагатай холбоо харилцаа, хамтын ажиллагааг тэлэхэд хувь нэмэр оруулж байна. Бид Лоринэт Сангийн дэмжлэгтэйгээр Вьетнам Улсын БСЯ-тай хамтран гэрийн орчинд хувиараа хүүхэд харах үйлчилгээний үндэсний стандартыг боловсруулж, Вьетнам Улс даяар тус үйлчилгээ үзүүлэгч нарыг сургахаар бэлтгэл ажлаа хийж байна. Энэ нь цаашид үүнтэй ижил төстэй ажлыг Монгол Улсын төртэй хамтран хийхэд сайн туршлага болно гэдэгт итгэлтэй байна.



**Морган Ланс**  
Уанскайн  
Гүйцэтгэх захирал



## ГОЛЛОХ ҮР ДҮНГҮҮД:

2020 онд Уанскай Баянзүрх дүүргийн гэр хороололд **Гэр бүлийн төвөө** байгуулсан

Хөтөлбөрийн хүрээнд нийт **859 эцэг, эх, асран хамгаалагчдыг** чадавхжуулж, тэд **1,959 хүүхдийг** гэртээ аюулгүй, зөв асран хүмүүжүүлж байна

12 улсын цэцэрлэг, төрийн бус байгууллагуудтай **хамтын ажиллагаа** өрнүүлж сургалтын цар хүрээгээ тэлсэн

“**Хамтдаа тоглоноо асрах бүлэг**”-т эцэг эх, асран хамгаалагч нарыг элсүүлж, хамтарсан байдлаар, ээлж үүсгэн хүүхдүүдээ асран халамжлах боломжтой эсэхийг туршиж байна

НҮБ-ын Хүүхдийн Сан санаачлан, орон нутгийн удирдлагатай хамтран байгуулсан “**Бага насны хүүхдийн хөгжлийн загвар төв**” дээр Уанскайтай хамтран ажиллах санал тавьсан. Тус загвар төвийг цаашдаа дүүргийн засаг даргын тамгын газар хариуцан ажиллуулах юм

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАРТ ТАНИГДСАН НЬ

Уанскай нь Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны яамны урилгаар эцэг эх, асран хамгаалагчдад чиглэсэн “Нялх, балчир насны хүүхдийн хөгжлийг дэмжих хөтөлбөр” боловсруулахад дэмжлэг үзүүлсэн. Мөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны урилгаар хүүхэд харах үйлчилгээний үндэсний стандартыг сайжруулах, хүүхэд харах үйлчилгээ үзүүлэгч нарыг бэлтгэх сургалтын чанар стандартыг сайжруулах ажлуудад өөрсдийн туршлага, мэдлэгээ хуваалцаж байна.

## Амжилтын түүх: Хүүхдээ асран, халамжлаад зогсохгүй хөгжлийг нь дэмждэг болсон нь

36 настай **Амарзаяа** нь нөхөр, гурван хүүхэд, байнгын асаргаа шаардлагатай хадам ээжийнхээ хамт амьдардаг. Тэрээр хоёр болон дөрвөн настай охид, хадам ээжийгээ асран халамжлаа шаардлагатай тул хөдөлмөр эрхлэх боломжгүй бөгөөд бүхий л цагаа гэрийн ажил хийж гэр бүлдээ зориулдаг байна.

Уанскай нь түүнийг Гэр бүлийн төвийн сургалтдаа урьсан ч анхандаа тус төвийн сургалт өөрт нь хэрэгтэй гэж бодоогүй тул тэрээр эргэлзсэн ч очиж үзэхээр шийджээ. Эргээд бодоход тус төвийн сургалтад хамрагдсандаа тэрээр маш их баяртай байдаг.

Амарзаяа хүүхдээ хардаг ээжийн хувьд хүүхдүүдийнхээ төлөө чадах бүхнээ хийдэг гэж боддог байсан ч сургалтад сууснаар тэднийхээ сайн сайхан байдлын төлөө илүү ихийг хийх боломжтой гэдгээ ойлгожээ. Сургагч багш нь түүнийг хүүхдээ юу хийж байгааг анзаарч, ажиглаж байсан эсэхийг асуухад өдөр тутамдаа тусгайлан цаг гарган ажиглаж үзээгүй гэдгээ анзаарчээ. Тэрээр 18 жилийн өмнө анх ээж болсон туршлагатай ээж боловч хүүхдүүдтэйгээ утга учиртай харилцаа хэрхэн үүсгэхийг сайн мэддэггүй байснаа ухаарсан байна.

Тухайлбал, түүний яриаг хүүхдүүд нь сайн хүлээж авахгүй байгааг анзаарсан байна. Жишээ нь, эцэг эхчүүд хүүхдэдээ ихэвчлэн “битгий гүй”, “битгий хоолоо асга” гэх мэтээр тушаасан өнгө аясаар харилцдаг. Гэтэл эдгээр үгсийг хүүхдүүд ойлгодоггүй, хүлээн авдаггүй. Харин оронд нь хүүхдүүддээ “гэртээ удаанаар алхаж яваарай”, “халбагаа сайн барьж, хоолоо идээрэй” гэх мэтээр ойлгомжтой зааварлаж хэлэх ёстой ажээ. Ингэж ярьдаг болсноор түүний бага охин ээжийгээ илүү сайн ойлгож, охины танин мэдэхүй, хэл ярианы чадвар илт сайжирч байгаа нь ажиглагджээ. Хоёр настай охин нь бүтэн өгүүлбэрээр өөрийгөө илэрхийлж, гэрт хэрэглэгдэж байгаа үгсийг хурдан сурч байв.

Амарзаяа гэртээ очоод сургалтаар сурсан мэдсэнээ нэгд нэгэнгүй биелүүлж, хүүхэдтэйгээ янз бүрийн сэдвээр ярилцах зуршилтай болсон. Жишээ нь, тэрээр “Би хоолоо хийж байна, төмсөө арилгаж байна.” гэж хэлэхэд түүний хоёр настай охин нь ээжийнхээ хийж буй үйлдлийг ажиглангаа эгчдээ “Ээж бидэнд хоол хийж байна. Хоёулаа аягаа угаах уу?” гэх зэргээр ярьдаг болжээ. Тэрээр сургалтад хамгийн идэвхтэй хамрагддаг ээжүүдийн нэг болсон бөгөөд хүүхдээ ажиглаж, тэдэнтэйгээ тасралтгүй ажиллаж эхэлснээс хойш түүний стресс бухимдал багассанаар гэр бүлийн харилцаа нь хүртэл сайжирчээ.

Төрсөн цагаас нь эхлэн хүүхдийнхээ хөгжилд анхаарах нь тэд цаашид амжилттай суралцах, ирээдүйд сайн сайхан амьдрахад ихээхэн нөлөөтэй болохыг ойлгосон учраас энэ төрлийн сургалтын хөтөлбөр бүх эцэг эх, асран хамгаалагч нар хамрагдах боломжтой байгаасай гэж Амарзаяа чин сэтгэлээсээ хүсэж байна.



“ Энэ хөтөлбөр гэр бүлийн бүхий л гишүүдэд үнэ цэнтэй юм. Сургалтад хамрагдсан эцэг эх, асран хамгаалагч гэртээ очоод сурсан зүйлээ хэрэгжүүлдэг ба эцэг эхчүүдэд хүүхдүүдээ хүмүүжүүлэхдээ амьдрал дээр ашиглаж болох практик мэдлэг ур чадварыг олгож, хүүхдүүдийн өсөлт хөгжилд шууд нөлөөлж байна. Хүүхдүүд хөгжөөд зогсохгүй, хүүхдүүдтэйгээ зөв харилцахад гэр бүлийн уур амьсгал сайжирч, эерэг тайван орчин бүрддэг. ”

# МОНГОЛ УЛСАД НОМООР ДАМЖУУЛАН БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ, БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ НЬ

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА:  
МОНГОЛ ДАХЬ АЗИЙН САН, 2021 ОНООС  
ХОЙШ ХЭРЭГЖИЖ БАЙГАА



The Asia Foundation

Азийн Сан нь 1954 онд байгуулагдсан ба Монгол Улсад 30 гаруй жилийн хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлэн ажиллаж байна. Эдгээр төсөл хөтөлбөрүүд нь сайн засаглал, хууль эрх зүйн орчныг бэхжүүлэх, эдийн засгийн хөгжил, эмэгтэйчүүдийн чадавхыг бэхжүүлэх, хүрээлэн буй орчны өөрчлөлтөд тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэх болон бүс нутгийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зэрэг 21-р зуунд Азид тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэж байна.

## ШИЙДВЭРЛЭХЭЭР ЗОРЬСОН АСУУДАЛ:

Монгол Улсын нийт насанд хүрэгчдийн 99 хувь (2020 оны байдлаар) нь бичиг үсэг тайлагдсан, сургуульд хамрагдалтын түвшин 98 хувь (2018 оны байдлаар) буюу харьцангуй өндөр боловсролын чанар, тэр дундаа бага насны хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлын асуудал анхаарал татаж байна. Нялх балчир болон бага насны хүүхдийн бие бялдар, хэл яриа, танин мэдэхүй, сэтгэл хөдлөл-нийгэмшихүйн хөгжлийг оновчтойгоор дэмжих нь тэдний амжилттай суралцах, ирээдүйд чанартай амьдрах эх үндэс болдог тухай ойлголт хангалтгүй байна. Энэ нь гэр бүлийн орчинд болон сургуулийн өмнөх боловсролын салбарт ч ажиглагддаг. Түүнчлэн, “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа-2018”-ны үр дүнгээс харахад:

- 3-4 настай хүүхдүүдийн зөвхөн 8.5 хувь нь бичиг үсэг таних, тоо тоолох ур чадварын стандарт түвшинд хүрдэг,
- Хүүхдүүдийн зөвхөн 28.6 хувь нь 3 болон түүнээс дээш тооны номтой бөгөөд 37.4 хувь нь ухаалаг утас, таблет, компьютероор тоглодог байна.

## БИДНИЙ ШИЙДЭЛ:

Бид Азийн Сангийн “Хамтдаа уншицгаая” төслийг дэмжин ажиллаж байгаа бөгөөд энэ төсөл нь эцэг эх, асран хамгаалагч, багш нар болон бусад холбогдох үйлчилгээ үзүүлэгчдэд бага насны хүүхэдтэй хамтдаа ном унших дадлыг сурталчилж, улмаар номыг хүүхдийн хөгжилд хувь нэмэр оруулах чухал хэрэгсэл болгон ашиглахад туслах зорилготой. Тухайлбал:

- 0-5 насны хүүхдэд ном уншиж өгөхийн ач холбогдол, үнэ цэнийг эцэг эх, асран хамгаалагч, багш нарт ойлгуулан таниулах
- Монгол хэл дээрх чанартай хүүхдийн ном, унших материал, хэрэглэгдэхүүний тоог нэмэгдүүлж, хүртээмжтэй болгох
- Хүүхдийн насны онцлогт тохирсон байдлаар үр дүнтэй унших арга техникийг үлгэрлэн харуулах уншлагын арга хэмжээнүүдийг хүртээмжтэйгээр зохион байгуулах
- Бага насны хүүхдэд ном унших дадлыг төлөвшүүлэхэд чиглэсэн зохицуулалтуудыг холбогдох төрийн бодлого, хөтөлбөрт тусгуулахыг зорьж байна.

Лоринэт Сан бол Монгол Улсад нийгмийн сайн сайхны төлөөх үйлсэд бодит хувь нэмрээ оруулж байгаа байгууллага бөгөөд Азийн Сангийн хүндэт санхүүжүүлэгчдийн нэг юм... Хөтөлбөрийн хамтран хэрэгжүүлэгчийн хувьд Лоринэт Сангийн ямагт үр дүнд суурилсан байдлаар төсөл хөтөлбөрөө дэмждэгт нь бид талархалтай байдаг. Маш нарийвчлан тодорхойлсон стратегийн зорилготойгоос гадна оновчтой хяналт шинжилгээ, үнэлгээнд зориулан нэмэлт хөрөнгө оруулалт гарган, урт хугацааны тогтвортой үр нөлөөг бий болгохын тулд ажилладаг нь хөгжлийн салбарт маш сайн жишээ, туршлага болж байна.



Марк Коениг  
Монгол дахь Азийн Сангийн  
Суурин төлөөлөгч



## ГОЛЛОХ ҮР ДУНГУУД:

Үлгэрийн цаг буюу хамтдаа ном унших арга хэмжээг 52 удаа зохион байгуулж, улмаар **836 бага насны хүүхдийн** хөгжилд номоор дамжуулан дэмжлэг үзүүллээ

Нийт **137 эцэг эх, асран хамгаалагч** болон **416 багш нар, холбогдох үйлчилгээ үзүүлэгчдийг** сургалт арга хэмжээнд хамруулж, бага насны хүүхдэд ном уншиж өгөх ач холбогдлыг таниулав

“Үлгэрийн цаг”, “Ирээдүйнх нь төлөө 15 минут” нөлөөллийн аяныг нийгмийн цахим сүлжээгээр **1.4 сая орчим хандалттай** өрнүүллээ

Монгол хэл дээрх, үнэ төлбөргүй “Хамтдаа уншицгаая” гар утасны аппликэйшнийг интернэттэй болон сүлжээгүй үед ашиглах байдлаар хөгжүүллээ

Нийт **189 хүүхдийн номыг** монгол хэл рүү орчуулж, монгол хэл дээрх хүүхдийн номын хүртээмжийг нэмэгдүүлсэн ба гар утасны аппликэйшн хэрэглэгчдийн тоо 4,419-д хүрч, давхардсан тоогоор 69,621 удаа цахим ном хамтдаа уншаад байна

## АЗИЙН САНГИЙН КОНСОРЦИУМ АРГА ЗҮЙ

Азийн Сан нь уг төслийн зарим голлох бүрэлдэхүүн хэсгүүдийг хэрэгжүүлэхдээ Гэр өргөө ТББ, Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг, Whyze агентлагтай хамтран ажиллаж байна. Нөлөөллийн аян өрнүүлж, орон нутгийн иргэдэд хүрч ажиллахдаа дотоодын чадварлаг байгууллагуудын мэдлэг туршлагыг төслийн цар хүрээ, үр дүнг нэмэгдүүлэхэд ашиглаж буй сайн туршлага болж байна.

## Амжилтын түүх: Бага насны хүүхдээ номоор дамжуулан хүмүүжүүлэх нь

**Халиун** нөхөр хоёр хүүхдийн хамт амьдардаг. 7 настай байхад нь ээж нь ажилдаа явахдаа аймгийн номын санд түүнийг орхиж явдаг болсноор анх номтой танилцжээ.

Тэрээр ном хүний амьдралд гэрэл гэгээ авчирч чаддаг гэдгийг сайн мэддэг учраас өөрийн хүүхдүүдээ ч мөн адил эртнээс номтой нөхөрлүүлэхээр 1 настай байх үеэс нь ном худалдан авч өгч эхэлжээ. Гэвч, хүүхдүүд нь номыг зүгээр л ураад хаячихдаг байжээ.

Хамтдаа уншицгаая төслийн хүрээнд гэрийнх нь ойролцоо Гэр өргөө олон нийтийн төв дээр Бямба гариг бүр ном уншиж өгөх Үлгэрийн цаг арга хэмжээ зохион байгуулагдаж байгааг олж мэдээд тэрээр ихэд сонирхон хүүхдүүдтэйгээ хамт оролцож эхэлсэн байна.

Хүүхдүүдэд нь Үлгэрийн цаг таалагдаж, тэд аажмаар номоор дамжуулан хөгжиж байгаа нь Халиунд ажиглагджээ. Түүний 3 настай охин гараа угаах нь чухал болох тухай ном уншиж өгөхийг сонсоод, үе тэнгийн найзуудтайгаа хамтдаа гараа угаах цэвэрхэн болох туршилт хийжээ. Гэртээ ирээд охин нь сонссон ном, хүүхдүүдтэй хамт гараа угаасан тухайгаа ярин, өөрөө гараа тогтмол угааж эхэлсэн байна.

Одоо Халиун гэртээ бяцхан номын сан үүсгэж, хүүхдүүддээ өдөр бүр ном уншиж өгдөг болжээ. 3 настай охин нь хэдийгээр уншиж сураагүй боловч урт бичвэртэй ном барьж ирээд өөрийн төсөөллөөр үлгэр ярьж эхэлсэн. Охины хэл яриа, танин мэдэхүйн хөгжил эрчимтэй явагдаж, цаг хугацаа явах тусам өөрийгөө илэрхийлэх чадвар нэмэгдэж байгаа нь ээжид нь анзаарагдаж байна.

Улаанбаатар хотод номын хүртээмж хангалтгүй бөгөөд тэр дундаа хүүхдийн насанд тохирсон агуулга, дүрслэл хийц бүхий ном олох нь тун хэцүү. Жишээ нь Халиун хүүхдүүддээ шүдээ угаахын ач холбогдлыг энгийнээр ойлгуулж чадах ном хайсан боловч олж чадаагүй. Харин “Гурван тоорой” үлгэр гэхэд 7 өөр хувилбар номын дэлгүүрүүдээр зарагдаж байв. Гэрийнх нь ойролцоо номын дэлгүүр байхгүй учир тэрээр амралтын өдрөөрөө хотын төв рүү орж, ном худалдаж авах шаардлага үүсдэг байна.

Үлгэрийн цаг арга хэмжээ нь Халиун шиг ээжүүдэд номын сангаас үнэгүй ном авах, хүүхдээ хөгжүүлэх боломжийг олгодог ба түүний хүүхдүүд одоо номыг хайрлан нандигнаж, утасны дэлгэц ширтэхийн оронд чөлөөт цагаа илүү бүтээлчээр өнгөрүүлж байна.

Халиун бусад эцэг эх, асран хамгаалагч нарыг ч мөн адил хүүхдэдээ төрсөн цагаас нь эхлэн ном уншиж өгөх, хүүхдээ номоор хөгжүүлэх ач холбогдлыг ойлгож мэдээсэй хэмээн хүсдэг.



“Миний хүүхдүүд над шиг номд хайртай байгаасай гэж хүссэн боловч тэд номыг нэг их сонирхохгүй байсан. Харин бид хамтдаа Үлгэрийн цаг арга хэмжээнд оролцдог болсноор тэд маань номд гардаг түүхүүдийг сонирхож эхэлсэн.

Миний хүүхдүүд номтой танилцаж, үеийнхээ хүүхдүүдтэй найзууд болж байхад, хүүхдүүдээ асраад гэртээ сууж буй ээж миний хувьд ч бас бусад ээжүүдтэй ярилцаж, хамтдаа цагийг өнгөрүүлэх нь таатай байдаг. Гэр өргөө олон нийтийн төв үргэлж таатай нөхөрсөг орчныг бүрдүүлэн, биднийг хүлээн авдаг баярладаг.

Хүүхдүүд маань номоос зөв сайн дадлуудыг сурч, ахмад настныг хүндэлдэг, хүнлэг энэрэнгүй хүн болж өсөөсэй гэж би хүсдэг. Гэрийн маань ойролцоо ийм сайхан үйл ажиллагаа хэрэгжиж байгаад би маш баяртай байна.

# ВЬЕТНАМ УЛСЫН ЗОРИЛТОТ БҮЛГИЙН ЗАЛУУЧУУДАД УР ЧАДВАР ЭЗЭМШҮҮЛЖ, ТОГТВОРТОЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТТЭЙ БОЛГОСОН НЬ

**ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА:**  
RESEARCH FOR EDUCATION AND CAREER  
HELP (REACH) ВЬЕТНАМ, 2018 – 2021



REACH нь 2004 онд байгуулагдсан, нийгмийн зорилтот бүлгийн залуучуудыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдсан техник мэргэжлийн сургалтад хамруулж, ажилд зуучлан амжилттай хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг үзүүлдэг нийгмийн төлөө үйлчилдэг байгууллага юм.

## ШИЙДВЭРЛЭХЭЭР ЗОРЬСОН АСУУДАЛ:

Вьетнам Улсад боловсрол, ур чадвар багатай зорилтот бүлгийн залуучууд ядууралд нэрвэгдэх, бусдаас хараат байх, өөртөө итгэх итгэл буурах зэрэг шалтгааны улмаас ажилгүйдэлд өртөх эсвэл цалин хөлс, үр бүтээмж багатай, баталгаагүй хөдөлмөр эрхлэх зэргээр эдийн засгийн хувьд хязгаарлагдмал боломжуудтай нүүр тулдаг. Жил бүр 1.6 сая залуучууд хөдөлмөрийн зах зээлд шинээр орж байгаа нь ажилгүйдлийн түвшнийг улам хүндрүүлж байгаа ба ажилгүй залуучуудын дийлэнх хувийг амьжиргааны түвшнээс доогуур орлоготой өрхийн, хөдөө орон нутгийн, боловсролын түвшин доогуур эсвэл үндэстний цөөнх залуучууд бүрдүүлж байна. Мөн түүнчлэн, хөдөлмөрийн зах зээл дээрх өрсөлдөөн ширүүсэж, ажил олгогчийн зүгээс тавигдах шаардлага нарийссаар байгаа нь эдгээр зорилтот бүлгийн залуучуудад зохистой хөдөлмөр эрхлэхэд нөхцөл байдлыг улам хүндрүүлж байна.

## БИДНИЙ ШИЙДЭЛ:

Бид REACH байгууллагатай хамтран Вьетнам Улс дахь залуучууд, тэр дундаа зорилтот бүлгийн залуучуудын ажилгүйдэл, ур чадварын үл нийцэл буюу хангалтгүй байдлыг бууруулахаар зорьж ажилласан. **REACH хөтөлбөр нь Зүүн Өмнөд Азидаа танигдсан, шилдэг техник мэргэжлийн сургалтын хөтөлбөр** хэмээн хүлээн зөвшөөрөгддөг.

- 3-6 сарын хугацаатай<sup>4</sup> эрчимжүүлсэн сургалтын хөтөлбөртэй бөгөөд англи хэлний сургалтын төлбөр, амьдрах ухааны сургалтууд, ажил мэргэжлийн чиг баримжаа болон техникийн ур чадваруудыг олгодог
- “Step up” нэртэй хөтөлбөрөөр сонсголын бэрхшээлтэй иргэдийг ажиллуулдаг үсчин, харааны бэрхшээлтэй иргэдийг ажиллуулдаг харилцагчийн үйлчилгээний төв, массаж эмчилгээг байгууллагынхаа дэргэд байгуулж, хөгжлийн ялгаатай иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмждэг.



## ГОЛЛОХ ҮР ДҮНГҮҮД:

4,519 залууст хүрч, **3,482 залуучуудыг сургалтад амжилттай хамруулсан**

Нийт төгсөгчдийн **78 хувийг ажилд зуучилсан**

Ажилд орсон төгсөгчдийн **79 хувийн орлого нэмэгдсэн** (сард дунджаар 241 ам.доллар)

**76 хувь** нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс (сард дунджаар 175 ам.доллар) **илүү цалин авч байсан**

**Хөгжлийн ялгаатай 55 залуучуудыг** Step Up дэд хөтөлбөрийн хүрээнд **сургасан** бөгөөд тэдний 52 хувийг амжилттай ажилд зуучилсан

## ХАМТРАГЧ БАЙГУУЛЛАГЫН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛСЭН НЬ

Лоринэт Сан нь REACH-ийн энэхүү хөтөлбөрийг бусад санхүүжүүлэгчидтэй хамтран санхүүжүүлсэн. Хөтөлбөрийн цар хүрээг илүү өргөжүүлэх боломжтой гэдгийг олж харсан учир тус байгууллагын удирдлагын баг, засаглалын чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн. Мөн REACH-ийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор зах зээлд өрсөлдөх чадвар өндөртэй, байгууллагын дэргэдэх нийгмийн бизнесийг байгуулахад дэмжлэг үзүүлсэн.

<sup>4</sup> Тогооч, үсчин, маркетинг борлуулалт, график дизайны 3 сарын курс болон 3D загварчлал, програмчлалын код бичих 6 сарын курс



## Амжилтын түүх: Сургууль завсардалтаас тэтгэлэгтэй оюутан болсон нь

**Хан Ти Ли (Hang Thi Ly)** нь Хмонг (Hmong) үндэстний цөөнхийн гэр бүлд мэндэлж, дутагдах гачигдахын бэрхшээлийг үзэж өссөн. Түүний эцэг, эх нь тариалан эрхэлдэг байсан бөгөөд таван бага насны хүүхдүүдээ чадан ядан тэжээж өсгөжээ. Хүнд хэцүү зүйл олон байсан боловч Ли үргэлж сургуульд сурч, ажил мэргэжилтэй болоод нийгэмдээ хувь нэмрээ оруулахыг хүсдэг байв.

Харамсалтай нь Лигийн эцэг эх коллежийн сургалтын төлбөрийг төлөх санхүүгийн боломжгүйн улмаас ахлах сургуулиа төгссөнийхөө дараа цаашид үргэлжлүүлэн сурч чадсангүй. Харин азаар найзуудаасаа REACH хөтөлбөрийн талаар сонсож, маркетинг борлуулалтын ангид нь элсэн орсон. Амьжиргааны түвшнээс доогуур орлоготой өрхийн залуучуудад тусалдаг REACH-ийн хөтөлбөрт хамрагдсанаар Ли мэргэжилтэй болсноос гадна харилцааны ур чадвар, амьдрах ухааны сургалтад хамрагдаж ур чадвар эзэмшсэн байна.

Ли REACH-д сурч байхдаа зөвхөн мэдлэг, ур чадвараа нэмэгдүүлээд зогсохгүй багш нар, үе тэнгийнхнийхээ нөхөрсөг халуун дулаан уур амьсгал, чин сэтгэлийн харилцаанд хамгийн их талархалтай байжээ. Тэрээр сурч байхдаа өвдөж, эмнэлэгт хэвтэх шаардлагатай болсон ба тэр хэцүү үед гэр бүлээсээ хол байхад нь REACH-ийнхэн түүнийг бүх талаар дэмжин тусалж хөтөлбөрөө амжилттай төгсөх урам зоригийг өгч байжээ.

Ичимхий даруу Хмонг охин өөртөө итгэлтэй болж, хөтөлбөрөө амжилттай төгсөөд мэргэжлийн төдийгүй хувь хүний хөгжлийн ур чадваруудыг эзэмшин, улмаар загварын компанид борлуулалтын ажилтнаар ажиллаж байна.

Тууштай хичээл зүтгэлийнхээ ачаар тэрээр 2022 онд Вьетнам Улсын RMIT их сургуулийн бакалаврын хөтөлбөрт суралцах тэтгэлгийн эзэн болсон ба энэ нь түүний хувьд ид шидийн мэт гайхалтай явдал болсон юм. Нэгэн цагт боловсрол эзэмших боломжгүй байсан Ли одоо олон улсын их сургуульд суралцаж байна.



“ Би ичимхий бүрэг, бусадтай сайн харилцаж чаддаггүй байсан тул харилцааны ур чадвараа сайжруулах, гэр бүлийнхээ санхүүд нэмэр болохоор ажилд хурдан орохын тулд борлуулалтаар сурахаар шийдсэн.

Миний хувьд REACH-ийн багш нар яг л гэр бүл шиг, миний хоёр дахь гэр шиг санагддаг. Тэд надад үргэлж тусалж, намайг ажил мэргэжилдээ амжилт олохыг чин сэтгэлээсээ хүсэж байсан. Би энэ хөтөлбөр болон багш нартаа үнэхээр их талархаж явдаг!

# ВЬЕТНАМ УЛСЫН ҮНДЭСТНИЙ ЦӨӨНХ ЗАЛУУ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛСЭН НЬ

**ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА:**  
KNOW ONE, TEACH ONE (KOTO)  
ВЬЕТНАМ, 2018 – 2021



КОВО нь Вьетнам Улсын эрсдэлт бүлгийн залуучуудыг зочлох үйлчилгээний цогц сургалтын хөтөлбөрөөр чадавхжуулдаг нийгмийн зорилтот байгууллага юм. Энэхүү зочлох үйлчилгээний хөтөлбөр нь 24 сарын хугацаанд сургалтын төвд байрлангаа суралцдаг олон улсад магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөр юм.

## ШИЙДВЭРЛЭХЭЭР ЗОРЬСОН АСУУДАЛ:

Меконгийн Хөгжлийн судалгааны институтын (Mekong Development Research Institute) судалгаагаар Вьетнам Улсын нийт хүн амын 15 хүрэхгүй хувь нь үндэстний цөөнх бөгөөд эдгээр иргэд нь тус улсын нэн ядуу иргэдийн 70 хувийг бүрдүүлж байна. Вьетнам Улсын нийгэм эдийн засгийн бүтэц зэрэг тогтолцооны суурь онцлогийн улмаас эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал анхаарал татах болсон ба эмэгтэйчүүд цалин хөлс багатай, албан бус ажлыг хийж, жендэрт суурилсан хүчирхийлэлд ихээр өртдөг байна. Тэр дундаа Вьетнам Улсын алслагдсан бүс нутагт амьдран сууж буй үндэстний цөөнх, эрсдэлт бүлгийн залуу эмэгтэйчүүдэд ур чадвар эзэмших, хөдөлмөр эрхлэх боломж маш хязгаарлагдмал байдаг.

## БИДНИЙ ШИЙДЭЛ:

Бид КОВО-ийн “Her Turn” – нэртэй Вьетнам Улсын хөдөө орон нутгийн үндэстний цөөнх эмэгтэйчүүдэд зориулсан, тусгайлсан 6 сарын хөтөлбөр болон 24 сар байрлан суралцах бизнес эрхлэх ур чадваруудыг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн. Хөтөлбөр нь нэмэлтээр англи хэлний ур чадварыг нэмэгдүүлж, амьдрах ухааны ур чадвараа хөгжүүлэх боломжийг олгосон ба дараах үндсэн зорилготой:

- Эмэгтэйчүүдэд хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай ур чадварыг олгох, зочид буудлын үйлчилгээ, бөөний худалдаа, аялал жуулчлал зэрэг салбарт ажилд ороход нь туслах эсвэл
- Дээрх салбаруудад бие даан гарааны бизнес эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх замаар эмэгтэйчүүд болон тэдний эргэн тойрны хүмүүсийн нийгэм, эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх.



## ГОЛЛОХ ҮР ДҮНГҮҮД:

Сургууль завсардсан, ажилгүй, шилжин суурьшигч, зорилтот бүлгийн болон ерх толгойлсон эмэгтэйчүүд зэрэг 12 үндэстний цөөнхийн бүлгийн **137 эмэгтэйг** мэргэжил сургалтын хөтөлбөрт хамруулсан

Ковид-19 цар тахлын үе байсан ч хөтөлбөрийн төгсөгч эмэгтэйчүүдийг **100 хувь ажилд зуучилсан**

Нийт төгсөгчдийн 100 хувь нь **орлогоо нэмэгдүүлж чадсан** ба төгсөгч эмэгтэйчүүд Вьетнам Улсын өнцөг булан бүрд байрлах ресторан, зочид буудал, амралтын газруудад ажиллаж байна

Төгсөгч эмэгтэйчүүдийн 6 хувь нь орон нутагтаа эргэн очиж, өөрсдийн жижиг **гэр буудлын бизнесийг нээж ажиллуулж эхэлсэн**

Ажил олгогчдын 75 хувь нь КОВО **төгсөгчдөд сэтгэл ханамжтай** байдаг бөгөөд КОВО **төгсөгч эмэгтэйчүүд нь хөтөлбөр төгсөөгүй хүмүүстэй харьцуулахад илүү сайн ажилладаг** хэмээн үнэлсэн бол, 25 хувь нь ялгаагүй ажилладаг хэмээн үнэлжээ

## КОВО НИЙГМИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ТАЙЛАН 2021

2001 оноос 2021 оны хооронд 20 жилийн хугацаанд КОВО хөтөлбөрийн төгсөгчид ойролцоогоор жилийн 22 хувийн хөрөнгө оруулалтын өгөөжийг бий болгож, КОВО хөтөлбөр сайн туршлага болохыг нотлон харуулжээ.

## Амжилтын түүх: Өөрчлөлтийг жинхэнэ утгаар нь авчирлаа!

**Тон Ти Бич Нок (Tong Thi Bich Ngoc)** нь Вьетнам Улсын хойд хэсгийн Лай Чау (Lai Chau) жижиг тосгонд төрсөн. Тэрээр Вьетнамын хамгийн эртний Гиау (Giáу) хэмээх үндэстний цөөнхийн бүлгээс гаралтай. Түүний аав 7-р ангид байхад нь нас барж, ээж нь ахуй амьдралаа авч явах болжээ. Нок мэргэжлийн сургалтад хамрагдах боломж байхгүй учраас ёс уламжлалын дагуу бол 20 нас хүрэхдээ хүнтэй сууж, будааны талбайд тариалан эрхлэх ёстой байсан аж. Харин тэр КОТО-ийн хөтөлбөрийн тухай олж мэджээ.

2019 оны 5 дугаар сард Нок Her Turn төслийн хамгийн анхны үндэстний цөөнх эмэгтэй суралцагчдын нэг болж, зочлох үйлчилгээний мэргэжлээр суралцахаар шийдсэнээр түүний амьдрал өөрчлөгдсөн юм.

Сургалтын эхний өдрөөс эхлэн олон бэрхшээл байсан ч Нок маш их хичээж байлаа. Хөдөөгийн жижиг тосгоноос том хотод ирээд ачаалал өндөртэй мэргэжлийн сургалтад хамрагдах нь тийм ч амар байсангүй. Гэхдээ тэр хурдан дасан зохицож, Ковид-19 цар тахлын үеийн гэнэтийн нөхцөл байдлыг ч амжилттай даван туулсан юм.

Нок англи хэлийг шамдан суралцаж, өдөр бүр хичээлээ давтсан тул маш хурдан сайжирч улмаар КОТО-ийн тухайн жилийн шилдэг сурагчаар шалгарч, түүгээр ч зогсохгүй Бокс Хилл Институтын (Box Hill Institute) олон улсын шилдэг сурагчийн шалгаруулалтад нэр дэвшсэн байна.

Тэрээр 2021 оны 5 дугаар сард хөтөлбөрөө амжилттай төгсөөд Ханой хотын шилдэг 7 Bridges Brewing Company шар айрагны үйлдвэрт ажиллаж байна.



“ КОТО хөтөлбөрт хамрагдахаасаа өмнө би бүрэг ичимхий, өөрийгөө яаж илэрхийлэхээ ч сайн мэддэггүй байсан. Харин хөтөлбөрт анх ирэхэд хүн бүр бие биедээ яг л гэр бүл шиг халамж анхаарал тавьдаг, багш нар нь маш нөхөрсөгөөр үргэлж тусалж дэмжиж байдаг нь гүн сэтгэгдэл төрүүлж, зөв газартаа ирсэн гэдгээ шууд мэдэрсэн. Харилцааны ур чадвараа сайжруулж, шинэ ур чадваруудыг хичээнгүйлэн суралцсанаас миний хамгийн дуртай хичээл “Амьдрах ухааны хичээл” байлаа.

Би таван одтой зочид буудалд ажиллаж, “Нэгийг мэдээд, нөгөөг заа” гэсэн КОТО-ийн үзэл санааны дагуу тосгондоо очоод хүүхдүүдэд Англи хэлний багш болох мөрөөдөлтэй. Манай тосгонд хар тамхи, мансууруулах бодисын хэрэглээ их бөгөөд боловсролоор дамжуулан тосгоныхондоо зөв мэдлэг мэдээлэл түгээж болно гэж бодож байна. Бас хэзээ нэг өдөр миний ирээдүйн төлөө золиосолсон бүхнийх нь хариуд ээж болон эмээгээ дагуулаад аялалд хамтдаа явахыг хүсэж байна.

# МОНГОЛ ЗАЛУУЧУУДЫГ БОЛОВСРОЛООС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ РҮҮ ШИЛЖИХЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛСЭН НЬ

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА:  
ЗОРИГ САН, 2019 – 2022



Зориг Сан нь 1998 онд байгуулагдсан хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, ил тод байдал зэрэг ардчиллын үнэт зүйлсийг нийгэмд түгээн дэлгэрүүлэх зорилготой байгууллага юм. Тус сан нь Сайн засаглал, Залуучууд болон Боловсрол, Орон нутгийн хөгжил гэсэн үндсэн хөтөлбөрүүдийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд залуучуудад чиглэсэн ууган төрийн бус байгууллагуудын нэг юм.

## ШИЙДВЭРЛЭХЭЭР ЗОРЬСОН АСУУДАЛ:

Монгол Улсад залуучуудын хөдөлмөр эрхлэлтэд нэн тэргүүнд тулгамдаж буй асуудлуудын нэг нь ур чадварын үл нийцэл буюу хангалтгүй байдал юм. Их дээд сургууль төгсөгчдийн талаас илүү хувь нь ур чадвар дутмагаас болж, ажлын байран дээр гараад ажил олгогчийн шаардлагад нийцдэггүй байна. Хэдийгээр монгол залуучуудын дээд боловсрол эзэмших нь нэмэгдэж, жил бүр 5 залуу тутмын 3 нь их дээд сургуульд элсэн суралцдаг боловч их, дээд сургууль төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдал төдийлөн сайн үр дүнг үзүүлэхгүй байгаа юм.

## БИДНИЙ ШИЙДЭЛ:

Бид Зориг Сангийн “Залуусын тогтвортой ажил эрхлэлтийг дэмжих хөтөлбөр” туршилтын төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн. Тус хөтөлбөр нь их, дээд сургуулиа төгсөөд хагас жилээс дээш хугацаа өнгөрч байгаа ч ажилд орж чадаагүй залуучуудын хэрэгцээ шаардлагад нийцүүлсэн хөтөлбөр юм. Бид Улаанбаатар хотын гэр хороололд амьдардаг эсвэл аймаг, орон нутгаас нийслэл хот руу шилжин суурьшсан залуучуудыг голчлон хөтөлбөртөө хамруулсан.

Хөтөлбөр нийт 6 удаагийн элсэлт авсан бөгөөд нэг ээлж нь 5 сарын хугацаанд үргэлжилж, залуучуудад:

- Ажил хайх, ажлын анкет бөглөх, хувийн намтраа боловсруулах, ярилцлагад орох, англи хэлээ сайжруулах, албан бичиг хэрэг хөтлөх, илтгэх ур чадварыг хөгжүүлэх гэх зэрэг ажилд ороход болон ажлын байран дээр түгээмэл шаардагдах үндсэн ур чадваруудыг эзэмшүүлж
- 3 сарын хугацаанд оролцогчдын сонирхож буй байгууллагад дадлага хийлгэх эсвэл туршилтын хугацаагаар ажиллуулж, туршлага хуримтлуулах боломж олгож
- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан зөвлөгөө мэдээллээр дамжуулан карьер хөгжлийн төлөвлөгөөгөө гаргахад дэмжлэг үзүүлсэн.



Лоринэт Сантай хамтран ажилласан нь бидний хувьд маш үнэ цэнтэй туршлага болсон. Тус сан манай “Залуусын тогтвортой ажил эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийг санхүүжүүлээд зогсохгүй, манай байгууллагын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, ялангуяа хяналт, шинжилгээ үнэлгээний системийг сайжруулахад дэмжлэг үзүүлсэн... Тэдний дэмжлэгтэйгээр бид хөтөлбөрөө амжилттай хэрэгжүүлэхээс гадна байгууллагын чадавхаа урт хугацаанд сайжруулах боломжтой болсон.



**Б.Цолмон**  
Зориг Сангийн  
Гүйцэтгэх захирал



## ГОЛЛОХ ҮР ДҮНГҮҮД:

3 жилийн хугацаанд тус хөтөлбөрт нийт **121 залуу** (83 хувь нь эмэгтэй) хамрагдсан

Хөтөлбөрт оролцогчдын 90 хувь нь 3 сарын хугацаанд **дадлага хийх** буюу туршилтын хугацаагаар нийт 82 байгууллагад ажиллаж, **ажлын туршлага хуримтлуулсан**

Хөтөлбөрт оролцогчдын 81 хувь нь хөтөлбөрөө төгссөнөөс хойш 6 хүртэлх сарын дотор ажилд орж, **үндсэн ажилтан болсон**

Хөтөлбөрт оролцогчдын 79 хувь нь хөтөлбөрөө төгссөнөөс хойш 6 сарын дотор **санхүүгийн байдлаа сайжруулсан**

Ажил олгогчдын 92 хувь нь хөтөлбөрийн **оролцогчдын мэдлэг, ур чадвар** хөтөлбөрийн явцад **сайжирсан** гэж үзсэн

## ХӨТӨЛБӨРИЙН ЦАР ХҮРЭЭГ АМЖИЛТТАЙ ТЭЛСЭН НЬ

Хөтөлбөрт оролцогч залуучуудын саналд үндэслэн, Зориг Сан Монгол улсын их сургуультай хамтран оюутнуудад зориулсан Карьер хөгжлийн төвийг байгуулсан. Ингэснээр хөтөлбөрийн агуулга, ижил төстэй дэмжлэгийг жил бүр 15,000 орчим оюутан авах боломжтой болж байна.

## Амжилтын түүх: Боловсролоос хөдөлмөр эрхлэлтэд амжилттай шилжсэн нь

**Баянбаатар** нь Их засаг их сургуулийг эрхзүйч мэргэжлээр төгссөнийхөө дараа 2 жилийн турш идэвхтэй ажил хайсан боловч ажилд орж чадаагүй байна.

Тэрээр ажлын анкет бөглөж, заримдаа ажлын ярилцлагад дуудагддаг боловч ихэвчлэн ажил олгогчдоос эргээд ямар нэгэн хариу ирдэггүй байжээ. Ямар алдаа гаргаад байгаагаа ч сайн мэддэггүй байв. Түүний хувийн дээд сургууль төгссөн нь, эсвэл бүрэг ичимхий байдал нь нөлөөлж байгаа эсэхийг хэлж мэдэхгүй байжээ. Цаг хугацаа өнгөрөх тусам өөртөө итгэлгүй болж, дахин ажил хайхаас халширч байлаа.

Тийнхүү учраа олохгүй явж байгаад Зориг Сангийн “Залуусын тогтвортой ажил эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн талаар олж мэдэн, хөтөлбөрт хамрагдсан байна. Тус хөтөлбөрөөс Баянбаатар ажлын ярилцлагад хэрхэн бэлтгэх тухай суралцаж, ярилцлагын өмнө боломжит ажлын байрны талаар сайн судалж мэдэх ёстой байдгийг ойлгож авав. Хандлага, зан чанарын тест хийгээд, ажил мэргэжлийнхээ ирээдүйн замнал ямар байвал зохилтой байх талаар ганцаарчилсан зөвлөгөө авчээ. Зөөлөн ур чадваруудаа хөгжүүлж, ажлын анкет бөглөх, хувийн намтраа боловсруулах, ярилцлагад амжилттай оролцоход шаардлагатай ур чадваруудыг эзэмшсэн байна.

Хөтөлбөрийн нөлөөгөөр тэр аажмаар өөрчлөгдөж байлаа. Эхлээд өөрийн биеийн хэлэмжээ зөв илэрхийлэх тухай сурав. Дараа нь хувийн намтраа дахин сайжруулж, холбогдох мэдээллээ эмх цэгцтэй оруулав. Ярилцлагад амжилттай орохын тулд тэрээр сайн бэлтгэж, улам өөртөө итгэлтэй болж байлаа. Мөн хамгийн шилдэг хуулийн фирмүүдийн нэг Авинекс фирмд дадлага хийх боломж олдсон юм.

Эцэст нь Баянбаатар энэ бүх хүчин чармайлтынхаа үр дүнд бүтэн цагийн ажилд орж чадсан юм. Тэрээр Соёмбо хуулийн фирмд хуульчийн туслахаар ажилд орж, 3 жилийн турш амжилттай ажилласан ба саяхан ажил мэргэжлийн карьераа дараагийн шат руу ахиулан, илүү өндөр цалинтай Номин холдинг группийн хууль зүйн хэлтэст ажилд оржээ.

Өмнө нь өөртөө итгэлгүй, ичимхий, үг дуу цөөтэй байсан Баянбаатар өнөөдөр ажил мэргэжилдээ эзэн байна гэдгийг ойлгож, өөрийн карьераа амжилттай бүтээж явна.



“ Хөтөлбөрт оролцох явцдаа би өөрийн үлгэр дуурайлал авах хүнээ олсон. Тэр хүн Зориг Сангийн өөр нэг хөтөлбөрийн төгсөгч байсан бөгөөд бидэнд урам зориг өгөх богино яриа хийсэн юм. Энэ үед би магадгүй амьдралдаа анх удаагаа мэргэжилтэн хүн хэрхэн биеэ авч явдгийг харж мэдэрсэн гэхэд хилсдэхгүй. Надад гайхалтай санагдаж, хэрхэн биеэ авч явж, хэрхэн ярьж байгаагаас нь их урам зориг авсан юм. Зориг Сангийн хөтөлбөр үнэхээр миний амьдралыг өөрчилж чадсан. ”

# МОНГОЛ УЛСАД ГЭР ХОРООЛЛЫН ЗАЛУУ ГЭР БҮЛҮҮДИЙН ӨРХИЙН АМЬЖИРГААГ ДЭМЖСЭН НЬ

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА:  
ДЭЛХИЙН ЗӨН МОНГОЛ,  
2018 – 2021

World Vision  
Mongolia

Дэлхийн Зөн байгууллага нь 1995 оноос хойш Монгол Улсын нэн эмзэг бүлгийн хүүхдүүдийн амьдралыг эергээр өөрчлөхийн тулд хүүхэд багачууд, олон нийт, гэр бүлүүдтэй ажиллаж ирсэн хүмүүнлэгийн байгууллага юм. Хүүхдийн хөгжил, өрхийн амьжиргааг дэмжих болон иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн урт хугацааны хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг.

## ШИЙДВЭРЛЭХЭЭР ЗОРЬСОН АСУУДАЛ:

Монгол Улсын нийт хүн амын 60 орчим хувь нь амьдардаг нийслэл Улаанбаатар хот руу хөдөө орон нутгаас шилжин суурьших нь элбэг үзэгдэл юм. Эдгээр шилжин суурьшигч иргэд илүү сайн боловсрол эзэмших, эдийн засгийн боломжуудыг эрэлхийлэн ирдэг ба ихэвчлэн Улаанбаатар хотын захаар байрладаг ус, дулааны шугам сүлжээнд холбогдоогүй, сургууль цэцэрлэгийн хүртээмж муутай гэр хорооллын бүсэд нүүн ирж суурьшдаг. Боловсрол, ур чадвараа ахиулах боломж хомс байдгийн улмаас эдгээр шинээр шилжин ирэгсэд албан салбарт ажилд орох боломж багатай байдаг ба ихэвчлэн ажилгүйчүүдийн эгнээнд нэгдэх эсвэл цалин хөлс багатай албан бус салбарт ажилладаг.

## БИДНИЙ ШИЙДЭЛ:

“Ядуурлаас гарах арга зам” хэмээн тодорхойлогдсон Дэлхийн Зөнгийн **“Төгсөлтийн аргачлал”** нь гэр бүлийн чадавхыг аажмаар сайжруулах замаар тэдний онцлог хэрэгцээ шаардлагад нийцүүлэн, өрхийг ядуурлаас гаргадаг аргачлал юм. Лоринэт Сан нь Дэлхийн Зөн байгууллагын дээрх аргачлалыг дэмжин, Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн гэр хороололд амьдран суугаа 150 залуу гэр бүлүүдийг чадавхжуулах зорилготой “Залуу гэр бүлийн өрхийн амьжиргааг дэмжих төсөл”-ийг санхүүжүүлсэн. Уг төсөл нь дараах онцлогтой байв:

- Айл өрх бүрийн нөхцөл байдалд нь тохируулан орлого нэмэгдүүлэх арга замыг тодорхойлж, өрхийн бизнесээ эхлүүлэхэд нь туслах эсвэл цалин хөлстэй ажилд зуучлах замаар **өрхийн амьжиргааг** дэмждэг
- Өрхүүдэд үндсэн хэрэгцээгээ хангах, хямралыг даван туулах, эрүүл мэнд боловсролын үйлчилгээнд хамрагдахад нь туслах замаар **нийгмийн хамгааллын** дэмжлэгийг үзүүлдэг
- Санхүүгийн ур чадвар олгох сургалт зохион байгуулж, шинэ өрхийн бизнесүүдийг албан ёсны банк, зээл, даатгалын үйлчилгээнд холбон зуучлах замаар тухайн өрхийн **санхүүгийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлдэг**
- Жендэрийн эрх тэгш байдалд суурилсан амьдрах ухааны ур чадваруудад сургаж, нийгмийн харилцаанд илүү идэвхтэй оролцоход нь дэмжлэг үзүүлэх замаар **нийгмийн баталгааг** хангадаг.



## ГОЛЛОХ ҮР ДУНГУУД:

Уг төслөөс **150 гэр бүл** буюу нийт 358 хүүхэд болон 285 насанд хүрэгчид үр шим хүртсэн

Нийт оролцогч гэр бүлүүдийн **99 хувь нь өрхийн амьжиргаагаа амжилттай дээшлүүлсэн**

71 гэр бүлийн **өрхийн бизнесийг дэмжиж, 57 оролцогчийг хөлстэй ажилд зуучилсан**

Нийт 141 гишүүнтэй **8 хуримтлалын бүлэг** байгуулагдсан ба нийт хуримтлалын хэмжээ нь 3000 ам.доллар хүрсэн

**Орон нутгийн засаг захиргаатай хамтран ажиллаж**, дүүргийн ЗДТГ-ын дэргэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилготой ажлын хэсэг байгуулж ажилласан

## ТӨСЛИЙН ЭЦСИЙН ҮНЭЛГЭЭ

Оролцогч залуу гэр бүлүүдийн сайн сайхан байдал хэрхэн сайжирч байгааг хөтөлбөрийн туршид хөндлөнгийн хараат бус үнэлгээгээр хэмжиж байсан бөгөөд энэхүү үнэлгээгээр төсөл нь өрхийн амьжиргааг дэмжихэд үр дүнтэй болох нь нотлогдсон. Тухайн айл өрхүүдийн сайн сайхан байдлыг хэмжихэд 2020 онд 9 үзүүлэлтийн 8 нь сайжирсан бол 2021 онд 11 үзүүлэлтийн 10 нь сайжирсан үр дүн гарсан.

## Амжилтын түүх: Гэртээ суудаг ээжээс бизнес эрхэлдэг эмэгтэй болсон нь

**Цолмон** нь нөхөр, хоёр хүүхдийн хамт амьдардаг. Тэр Санко санхүү менежментийн сургуульд сурч байхдаа гэр бүлтэй болсон бөгөөд 2012 онд анхны охиноо төрүүлснээс хойш 5 жилийн турш гэртээ сууж хүүхдээ харжээ. Ингээд 2016 онд хүү нь мэндлэхэд хүүгээ бас асарч халамжилсан байна.

Өрхийн амьжиргаагаа дэмжихийн тулд тэрээр янз бүрийн орлого олох оролдлогуудыг хийжээ. Өөрөө цагаан идээ борлуулж, нөхөр нь гар утасны сэлбэг зардаглангуу ажиллуулж үзсэн. Гэсэн хэдий ч тэдний орлого нь өрхийн амьжиргаагаа залгуулж хүрэлцэхгүй байлаа. Нэг настай хүүг нь харах хүн байхгүй тул нялх хүүгээ дагуулаад оёдлын цехэд хүртэл туслахаар ажиллаж үзжээ. Гэтэл тун удалгүй хүү нь бяцхан ахуйн осолд орсон тул тэр ажлаа болих хэрэгтэй болов. Эдгээр асуудал бэрхшээлүүд түүнийг мохоосонгүй. Тэрээр гэрээсээ хүүхдийн амны алчуур гэх мэт жижиг эд зүйлсийг оёж эхэлжээ. Үнэхээр хичээнгүйлэн оёдог байсан тул жаахан боловч байнгын захиалгууд ирдэг болж, өөрөө захиалгаа амжихгүй болж, өөрийн нөхрөө, их сургуулийн найзаа нөхөртэй нь хамт ажилдаа татан оролцууллаа. Тэдний хоёр гэр бүл нийлсэн бяцхан өрхийн бизнес арай гайгүй болж байтал Ковид-19 цар тахал дэгдэж орхив.

Цар тахлын улмаас хатуу хөл хорио тогтоосон нь тэдний өрхийн орлогод нөлөөлж, хүнд нөхцөл байдалд байх үедээ Дэлхийн Зөн Монгол байгууллагын “Залуу гэр бүлийн өрхийн амьжиргааг дэмжих төсөл”-ийн талаар сонсож, хөтөлбөрт хамрагдахаар болжээ.

Тэрээр хөтөлбөрөөс өрхийн бизнес хэрхэн эрхлэх тухай сурч, гэр бүлдээ болон бизнестээ зориулж мөнгө хуримтлуулах тухай ойлголттой болжээ. Ковид-19 цар тахлын хатуу хөл хорионы үеэр тэдний гэр бүл хоол хүнсний тусламж авсан тул оёдол хийгээд олсон жаахан орлогоороо хоол хүнс авахын оронд даавуу материалаа татан авч нөөцлөх боломжтой болжээ. Мөн төсөлдөө хүсэлт гарган товч хаддаг тусгай машиныг авч чадсанаар нэг товч хадах хугацааг 10 минутаас 1 минут хүртэл багасгаж, бүтээмжээ нэмэгдүүлсэн байна.

Тэдний гэр бүл шаардлагатай байгаа оёдлын тусгай машинуудаа нэг нэгээр нь худалдан авахын тулд хуримтлал үүсгэж эхэлжээ. Алхам алхмаар өрхийн бизнес нь цэцэглэж эхэлсэн бөгөөд өнөөдөр тэрээр 8 ээжийг ажлын байраар хангаж, бизнесийн орлого нь 10 дахин өссөн амжилттай явж байна. Тэрээр цаашид өөрсдийн оёсон бүтээгдэхүүнээ шууд хэрэглэгчдэд хүргэх дэлгүүртэй болох зорилго өвөртлөн хичээнгүйлэн хөдөлмөрлөсөөр байна.



“ Би хуримтлалын бүлэгт элсэж, бидний хэдэн нөхөд бага багаар долоо хоног бүр хуримтлал үүсгэн нэгэндээ тусалж эхэлсэн. Их хэмжээний хуримтлал байгаагүй ч би хуримтлалын ач холбогдлыг ойлгож, алхам алхмаар хуримтлуулах зуршилтай болсон.

Мөн өрхийн болон бизнесийн орлого зарлагаа нэгд нэгэнгүй хэрхэн бүртгэхийг сурсан. Манай өрхийн бизнесийн хувьд бараа материалдаа хэдэн төгрөг зарцуулж, түүнээсээ хэдэн төгрөгийн орлого олж байгаагаа мэдэх нь чухал байсан.

Хөтөлбөр надад бизнес болон гэр бүлийнхээ төлөө төлөвлөж, тууштай байхыг зааж сургасан. Би одоо яахаа мэдэхгүй байсан залуу ээж биш, өөрөөрөө бахархдаг бизнес эрхлэгч эмэгтэй болсон.

## КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕД ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖ ҮЗҮҮЛСЭН НЬ

Цар тахлын гэнэтийн нөхцөл байдлын үед бид хамтрагч байгууллагууд болон айл өрхүүдэд яаралтай хүмүүнлэгийн тусламж үзүүлэх хэрэгцээ шаардлага гарсан ба тухай бүрд нь тохирох арга хэмжээг авч ажиллалаа.

Тухайлбал, цар тахлын хатуу хөл хорионы үеэр зорилтот бүлгийн өрхүүдийг цар тахлыг даван туулахад нь туслах зорилгоор буцалтгүй тусламж олгосон. Ингэхдээ Дэлхийн Зөн Монгол байгууллагаар дамжуулан орон нутгийн засаг захиргаатай хамтран ажиллаж, Улаанбаатар хотын гэр хороололд амьдран суугаа айл өрхүүдэд дараах эд материал болон мөнгөн тусламжийг хүргэсэн:

- **1000 зорилтот өрхийн** 4,907 хүнд хоол хүнс, ариун цэврийн багц тусламж
- 1-12-р ангийн **1000 сурагчдад** цүнх, хичээлийн хэрэгслийн багц
- **1000 зорилтот өрхийн** 4,746 хүнд бэлэн мөнгөний тусламж

Үндэсний хэмжээнд хатуу хөл хорио тогтоосны улмаас хамтрагч байгууллагууд маань үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлэхэд хүндрэл үүсэж байсан төдийгүй заримынх нь хувьд үйл ажиллагаагаа бүрэн зогсоох эрсдэлтэй тулж байв.

- Бид хамтрагч байгууллага КОТО-д тусламж үзүүлснээр **100 хүүхэд хоол ундтай, аюулгүй орчинд амьдрах, боловсрол сургалтад үргэлжлүүлэн хамрагдах** боломжийг бүрдүүлсэн. Бидний санхүүгийн дэмжлэг цар тахлын хөл хорионы үеэр санхүүгийн боломжгүйн улмаас гэртээ харьж чадаагүй үндэстний цөөнх эмэгтэйчүүдийн хоол хүнс, орон байр, хэрэглээний зардал болон төвийн ажилтнуудын цалин, сургалтын материалд зарцуулагдсан.
- Бид цар тахлын улмаас хөтөлбөрийн үйл ажиллагаа нь доголдоод байсан Уанскай Вьетнамд хөтөлбөрөө цахим болон танхимаар хослуулсан хэлбэрт шилжүүлэн **гэрийн орчинд хувиараа хүүхэд харах үйлчилгээ үзүүлэгч нарын сургалтаа дахин үргэлжлүүлэхэд** нь дэмжлэг үзүүлсэн. Санхүүгийн дэмжлэгээрээ бид 400 суралцагчдад дижитал таблет (ингэснээр тэд сургалтаа цахимаар үргэлжлүүлэх боломжтой болсон), сургагч багш нарт зөврийн интернэтийн төхөөрөмж, бичлэг хийх гар утас (ингэснээр өндөр чанартай контент бэлтгэх боломжтой болсон) зэрэг төхөөрөмжүүдээр хангасан ба бага насны хүүхдийн асаргаа халамжийн талаарх болон Ковид-19 цар тахалтай холбоотой цахим сургалтын материал бэлтгэхэд нь тусламж үзүүлсэн юм.





## СИСТЕМИЙН ТҮВШНИЙ ҮР НӨЛӨӨ: ЯВЦЫН ҮР ДҮН



Монгол Улсад нийгмийн сайн сайхны төлөөх төсөл, хөтөлбөрүүд сүүлийн үед идэвхжиж байгаа энэ үед хандивлагч байгууллагууд болон иргэний нийгэм, төр, хувийн хэвшлийн төлөөллүүд салбар дундын уялдаа холбоог бэхжүүлж, хамтын ажиллагаагаа илүү өргөжүүлэх нь зүйтэй. Лоринэт Сан нь энэ чиглэлээр хүчин чармайлт гаргаж, оролцогч талуудын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд манлайлан оролцдог төдийгүй судалгаа мэдлэгийг бүтээх, хуваалцах замаар боломжит нөөцүүдийг татан төвлөрүүлэх, системийн түвшинд түгээн дэлгэрүүлэхийг эрмэлзэж байна. Улмаар төрийн авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд сайн туршлагуудыг нэвтрүүлэх, цар хүрээг нь нэмэгдүүлэхээр зорин ажиллаж байна.

Энэхүү бүлэгт системийн түвшний үр нөлөөнд чиглэсэн бидний хүчин чармайлт, явцын үр дүнгийнхээ тухай хуваалцлаа.

## МОНГОЛЫН БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН СҮЛЖЭЭГ БАЙГУУЛАХАД МАНЛАЙЛАН ОРОЛЦСОН НЬ

Лоринэт Сан нь Монгол Улсад Бага насны хүүхдийн хөгжил, боловсролын салбарыг хөгжүүлэх, хамтын хүчээр урт хугацааны, тогтвортой үр нөлөөг бий болгох үйлсэд хувь нэмрээ оруулахыг хичээн ажилладаг билээ.

Энэ ч утгаараа, бид 2022 онд Боловсрол, шинжлэх ухааны яам болон НҮБ-ын Хүүхдийн Сангийн хамтын санаачилгаар “Монголын бага насны хүүхдийн хөгжлийн сүлжээ”-г байгуулсан. Монгол Улсад бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих зорилготой гол оролцогч талууд хоорондын хамтын ажиллагааг өрнүүлэх, харилцаа холбоог бэхжүүлэх, нэгдмэл зорилгоор ажиллахын тулд үндэсний сүлжээг байгуулах нь нэн чухал байсан билээ.

**Монголын бага насны хүүхдийн хөгжлийн сүлжээ** нь **бага насны хүүхдийн хөгжил** (эрүүл мэнд, боловсрол, асаргаа халамж, хоол тэжээл, хүүхэд хамгаалал)-ийг дэмжих чиглэлээр ажилладаг **төр, хувийн хэвшил, иргэний нийгэм, боловсрол эрдэм шинжилгээний байгууллагууд болон хөгжлийн түнш байгууллагуудын хамтын ажиллагааг хөхүүлэн дэмжиж, мэдлэг мэдээлэл хуваалцах** зорилготой байгуулагдсан.

2022-2023 онд бид сүлжээний удирдах хорооны гишүүнээр ажиллаж байгаа бөгөөд санхүүгийн болон хүний нөөцөө энэхүү үйлсэд тусгайлан зориулан ажиллаж байна. Тухайлбал, бид сүлжээний удирдамжийг боловсруулж, гишүүд хоорондын хамтын ажиллагаа бэхжүүлэх, холбогдох бодлогын баримт бичиг боловсруулах явцад гишүүдийг оролцуулах болон цаашид сүлжээний тогтвортой байдлыг хангах зэрэг үйл ажиллагаанд манлайлан ажиллаж байна.

2023 оны эхний улирлын байдлаар уг сүлжээнд НҮБ-ын Хүүхдийн Сан, Дэлхийн Банк, Жайка, ХНХЯ, Монгол Улсын Багшийн их сургуулийн Сургуулийн өмнөх боловсролын сургууль, Монголын хүүхэд харах үйлчилгээ эрхлэгчдийн нэгдсэн холбоо, Дэлхийн Зөн Монгол, Монголын боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг, Монгол контент зэрэг гуч гаруй байгууллагуудын төлөөлөл нэгдээд байна.

Сүлжээний гишүүн байгууллагууд нэгдэн нийлж, Монгол Улсад бага насны хүүхдэд чанартай, хүртээмжтэй үйлчилгээ хүргэхийн тулд төртэй хамтран ажиллаж, бодлогын түвшинд тухайн асуудлыг хэлэлцэх, шийдвэрлэх явцад гол оролцогч талуудын саналыг тусгахад ач холбогдол өгөн ажиллаж байна. Үүнтэй холбогдуулан, БШУЯ бага насны хүүхдийн цогц хөгжлийн бодлого шинэчлэн боловсруулж буй талаараа мэдээлэл хуваалцаж, сүлжээний гишүүн байгууллагуудаас санал зөвлөмж авсан.

Гишүүд хоорондоо сүлжээгээр дамжуулан мэдлэг туршлагаа солилцох, салбарын уялдаа холбоог сайжруулах нөхцөл боломж бүрдэж байгааг онцолж, бодит хамтын ажиллагаа өрнүүлэх чиглэлд анхааран ажиллаж байна.



Лоринэт Сангийн Монгол Улс дахь хөтөлбөр нь бага насны хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамж хамгааллын үйлчилгээний чанар, үр өгөөжийг сайжруулахад алхам алхмаар, эерэг сайнаар нөлөөлж байна. Тун сангийн санаачилга, манлайлах оролцоотойгоор Монгол Улсад бага насны хүүхдийн хөгжлийн үндэсний сүлжээ амжилттай эхэлж байна. Энэхүү сүлжээ нь Монгол Улсын Засгийн газрын урт болон дунд хугацааны хөгжлийн зорилтуудыг ханган хэрэгжүүлэхэд хувь нэмэр болохуйц хүний болон санхүүгийн нөөцийг бүрдүүлэн хөгжүүлэх, дотоод гадаадын хөрөнгө оруулагчид, хөгжлийн түншүүдийн үр өгөөжтэй хамтын ажиллагааны “сайн загвар” болно хэмээн итгэж, бас дэмжин ажиллаж байна.



**Түмэгийн Цэндсүрэн (Ph.D)**  
НҮБ-ын Хүүхдийн Сангийн  
Сургуулийн өмнөх  
боловсролын мэргэжилтэн

## МОНГОЛ УЛСЫН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТӨД ОЛОН УЛСЫН САЙН ТУРШЛАГЫГ ХУВААЛЦСАН НЬ

**Монгол Улсын Засгийн газрын урилгаар Бага насны хүүхдийн цогц хөгжлийн бодлогыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэгт ажилласан** нь манай сангийн хувьд нэр төрийн хэрэг болсон юм.

2022 онд тус ажлын хэсэг нь байгуулагдаж, үндэсний хэмжээнд “Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээ” бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулсан. Тус ажлын хэсэгт боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамдын мэргэжилтнүүд багтсан бөгөөд Лоринэт Сан нь НҮБ-ын Хүүхдийн Сангийн хамтаар хөгжлийн салбарын голлох төлөөлөл болон оролцсон билээ.

Бидний зүгээс бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих олон улсын сайн туршлага, хүчин чармайлтуудын талаар судалж эмхэтгэн, бодлого боловсруулахад олон улсын туршлагаас суралцах боломжийг бүрдүүлсэн. Тухайлбал, бид баримт бичгийн судалгаа хийснээс гадна олон улсын зөвлөх мэргэжилтнүүд болон холбогдох сүлжээ байгууллагуудтай зөвлөлдөж, шилдэг санал санаачилга, сайн туршлагаудыг Европын Холбооны улсуудад бодлогын түвшинд хэрхэн хэрэгжүүлж байгаа талаарх мэдээллийг бэлтгэн ажлын хэсэгт хүргүүлсэн.

Түүнээс гадна тус бодлогын баримт бичигт Монголын бага насны хүүхдийн хөгжлийн сүлжээний гишүүдээс санал авах ажлыг зохион байгуулах хүсэлт ажлын хэсгээс ирсэн бөгөөд бид үүнийг бодит ажил хэрэг болгосон юм. Ажлын хэсэг нь 2022 онд энэхүү бодлогын баримт бичгийг Засгийн газарт батлуулахаар өргөн бариад байна.

Мөн түүнчлэн, Лоринэт Сангийн залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлд хуримтлуулсан туршлагыг үндэслэн, 2022 онд ХНХЯ-аас залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг сайжруулах бодлогын баримт бичигт санал өгөх ажилд урин оролцуулж байв.



## ХАМТРАГЧ БАЙГУУЛЛАГУУДЫНХАА ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЖ, ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛД ТЭМҮҮЛЭХ НЬ

Бид төсөл хөтөлбөрүүдэд санхүүжилт олгохоос гадна тэдгээрийг хэрэгжүүлж байгаа хамтрагч байгууллагуудынхаа чадавхыг бэхжүүлэхэд хүчин чармайлт гаргах нь зүйтэй хэмээн итгэдэг билээ. Ингэснээр тэд амжилтаа улам ахиулж, цаашид илүү үр дүнтэй, урт хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулж, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах нөхцөл бүрдэх юм. Тиймээс бид хамтрагч байгууллагууддаа шинэ санал санаачилгыг туршиж үзэх, үйл ажиллагааны цар хүрээгээ тэлэх, байгууллагын үйл ажиллагаагаа сайжруулах боломжуудыг олгохыг хичээдэг билээ.

- i. Лоринэт Сан REACH-ийн Гүйцэтгэх захиралтай хамтран, байгууллагын үйл ажиллагааг түүнээс хэт хамааралтай байсныг өөрчилж, сайн гүйцэтгэлтэй удирдлагын багтай болгосон. Одоо удирдлагын баг нь санхүүжилт олох, холбоо сүлжээгээ тэлэх зэрэг чухал стратегийн шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлдэг зөвлөх хороотой болон ажиллаж байна.

Мөн бид зах зээлд өрсөлдөх чадвар өндөртэй, REACH-ийн алсын хараа, зорилго зорилттой нийцсэн нийгмийн бизнесүүдийг байгуулахад дэмжлэг үзүүлсэн юм. Үр дүнд нь байгууллагын дэргэд 2 нийгмийн бизнесийг байгуулж, тэдгээрийн орлогоор REACH-д тогтвортой санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгохоор зорьж байна. Тухайлбал:

- **VIEWZZ** нь REACH-ийн сургагч багш нарыг бэлтгэж, ажлын байран дээрх сургалтыг оюутнуудад санал болгодог. VIEWZZ жилийн дотор 200 хувийн өсөлт үзүүлсэн ба REACH-ийн санхүүгийн тогтвортой байдалд хувь нэмрээ оруулна.
- **ЕМ үсчин** нэг дор бизнес эрхлэх болон хөтөлбөрийн суралцагчдыг сургах давхар боломжийг олгодог. Энэ бизнес нь одоогоор дөнгөж эхлээд байгаа бөгөөд ирээдүйд өөрсдийн үсчний газраа нээх өндөр магадлалтай чадварлаг үсчдийг бэлтгэж байна.

Бид санхүүжүүлэгч байгууллагуудынхаа туслалцаатайгаар амжилттай ажилладаг. Лоринэт Сан нь Вьетнам Улсын зорилтот бүлгийн залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэдний ирээдүйн сайн сайхны төлөө бидэнтэй хамтран ажиллаж байна. Мөн түүнчлэн, манай байгууллагын дэргэдэх нийгмийн бизнес Viewzz-ийг анх эхлүүлэхэд хөрөнгө оруулж, бидний үйл ажиллагаа, урт хугацааны санхүүгийн тогтвортой байдлыг хангахад хувь нэмрээ оруулсан.

Там Пам  
REACH-ийн  
Гүйцэтгэх захирал



- ii. Бид **Зориг Сангийн** залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг бүрэн санхүүжүүлснээс гадна хөтөлбөр дууссаны дараа оролцогч нэг бүрийн өөрчлөлт, үр нөлөөг үнэлэх нэмэлт санхүүжилт олгосон юм. Бидний идэвхтэй хамтын ажиллагааны үр дүнд Зориг Сан бусад 15 хөтөлбөрүүдээсээ энэхүү хөтөлбөрийг онцлон сонгож, Австралийн Элчин сайдын яамнаас санхүүжилт авч, хөтөлбөрийнхөө цар хүрээг тэлэх шийдвэр гаргасан юм. Зориг Сан оролцогчдод гарсан эерэг өөрчлөлтийг баталгаажуулсан баримт мэдээлэл цуглуулахаас гадна асуудлын суурь шалтгаан руу чиглэсэн шийдэл буюу их дээд сургуулиудын карьер хөгжлийн үйлчилгээг сайжруулах санал боловсруулсан нь уг санхүүжилтийг босгоход голлон нөлөөлсөн.

Бидний хамтын ажиллагааны явцад Зориг Сан дотоод хяналт шинжилгээ, үнэлгээний чадавхаа бэхжүүлж, илүү урт хугацааны үр дүнд чиглэсэн байгууллага болж байна.

- iii. **Дэлхийн Зөн Монголын** өрхийн амьжиргааг дэмжих аргачлал нь 36 сарын хугацаанд зорилтот бүлгийн айл өрхүүдийн чадавхыг бэхжүүлж, тэднийг ядуурлаас гарахад дэмжлэг үзүүлдэг хөтөлбөр юм. Лоринэт Сан нь энэхүү аргачлалыг өөрчлөн туршиж, залуу өрхүүдийг түлхүү дэмжихээс гадна, хэрэгжилтийн хугацааг 18 сар болгон богиносгосон билээ. Үүний үр дүнд хөтөлбөрийн үр ашгийг нэмэгдүүлсэн тул Дэлхийн Зөн Монгол байгууллага тус шинэчилсэн аргачлалыг хөдөө орон нутгийн хөтөлбөрүүддээ нэвтрүүлсэн. Мөн түүнчлэн, Дэлхийн Зөн Монгол нь хөтөлбөрийн арга аргачлалыг амжилттай өөрчилсөн туршлагаа 2020 оны Дэлхийн Зөн олон улсын байгууллагын бүс нутгийн хурал дээр сайн туршлага болгон танилцуулсан юм.





## ХӨТӨЛБӨРҮҮДИЙНХЭЭ ЦАР ХҮРЭЭГ ТЭЛЭХИЙН ТУЛД ТӨРТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАХ НЬ

Уанскай нь олон жилийн турш Азийн улс орнуудын зорилтот айл өрхүүдийн хүүхдүүдэд аюулгүй ээлтэй орчныг бүрдүүлж, тэднийг амжилттай сурч хөгжихөд хувь нэмрээ оруулдаг. Тийм ч учраас Лоринэт Сан тус байгууллагын Монгол болон Вьетнам дахь үйл ажиллагааг зэрэг дэмжин ажиллаж байна. Уанскайн Вьетнам дахь хөтөлбөр нь гэрийн орчинд хувиараа хүүхэд харах үйлчилгээ үзүүлэгч нарыг сургаж бэлтгэх бөгөөд Бага насны хүүхдийн сургалтын загвар төвөөрөө дамжуулан бага насны хүүхдүүдэд чанартай асаргаа, халамж, боловсролын үйлчилгээг хүргэж байна.

Уанскайн хувьд үйл ажиллагаа явуулдаг улс орон бүртээ төртэй хамтран ажиллах нь чухал байдаг ба Вьетнам дахь хөтөлбөр амжилт гаргасан нь тус улсын Боловсрол, сургалтын яам (БСЯ)-ны анхаарлыг татсан юм. Харвардын Ти Эйч Чан нийгмийн эрүүл мэндийн сургууль Уанскайн хөтөлбөрийн чанарын үнэлгээг хийж, хөтөлбөрийн үр дүнг баталгаажуулснаар БСЯ нь тус сургалтын хөтөлбөрийг туршилт хэлбэрээр хэрэгжүүлэхээр болсон.

**Энэ нь бидний дэмжсэн хөтөлбөрийг төрийн зүгээс үнэлж, тогтолцоонд нэвтрүүлсэн бахархам үйл явдал** болсон бөгөөд Вьетнам Улсын БСЯ нь Уанскайтай хамтран, гэрийн орчинд хувиараа хүүхэд харах үйлчилгээ үзүүлэгчийн сургалтын хөтөлбөрийг дахин загварчилж, 2023 онд таван шинэ мужид туршиж хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Засгийн газрын гардан хэрэгжүүлэх туршилтын хөтөлбөрийг төлөвлөх, загварчлах нь нэн чухал ач холбогдолтой учраас бидний зүгээс уг үе шатад нэмэлт санхүүжилт олгохоор шийдсэн. Ингэснээр манай байгууллагын хувьд төртэй хэрхэн үр дүнтэй хамтран ажиллах, сайн арга аргачлал, туршлагуудыг хэрхэн тогтолцоонд нэвтрүүлэх, цар хүрээг нь тэлэх талаар туршлагатай болох бөгөөд улмаар Монгол Улсад энэхүү туршлагаа хэрэгжүүлэх боломж нээгдэх юм.



## МЭДЛЭГ БҮТЭЭЖ, ХУВААЛЦСАН НЬ



Үйл ажиллагааныхаа үндсэн чиглэлүүдийнхээ хүрээнд мэдлэг, мэдээллийг бий болгох нь Лоринэт Сангийн ажлын бас нэгэн үндсэн цөм юм. Тэр ч утгаараа бид мэдлэг бүтээх, хуваалцах ажилд хүний нөөц болон санхүүгийн нөөцөө тусгайлан хуваарилж, зорилтот бүлгийнхээ хэрэгцээ шаардлагыг тодорхойлохоос гадна сайн туршлагаас суралцаж, ойлгож мэдсэнээ бусад оролцогч талуудтай хуваалцдаг билээ. Ингэснээр аливаа асуудлыг шийдвэрлэх оновчтой шийдлийг илүү өргөн цар хүрээнд түгээж, системийн түвшинд эерэг өөрчлөлтийг бий болгох зорилготой байдаг. Судалгаа шинжилгээний ажлуудын маань талаар илүү ихийг мэдэхийг хүсвэл манай вэбсайтад хандана уу:  
<https://www.lorinetfoundation.org/impact/>

Энэхүү бүлэгт сүүлийн 5 жилийн хугацаанд бидний хийж гүйцэтгэсэн гол судалгааны ажлуудын талаар өгүүллээ.

## УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛОЛД АМЬДРАН СУУГАА ИРГЭДИЙН ХЭРЭГЦЭЭГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА – 2017



Анх сангийн үйл ажиллагаагаа эхэлж байхад бид Улаанбаатар хот дахь гэр хорооллын нөхцөл байдлыг илүү цогцоор нь ойлгож мэдэх шаардлагатай байлаа. Засаг захиргааны бүтэц зохион байгуулалтаас эхлээд холбогдох статистик мэдээлэл, иргэдийн хэрэгцээ шаардлага, нийгмийн тулгамдсан асуудлууд зэргийг ойлгох нь чухал байв. Энэ судалгаагаар бид зорилтот бүлгийн иргэд, тэдний гол асуудлуудыг тодорхойлж, орон нутгийн засаг захиргааны болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг судлан, хамтран ажиллах боломжийг эрэлхийлэх зорилготой байсан. Дараах хоёр үндсэн хоёр хэсэг бүхий судалгааг бидний захиалгаар Гэр өргөө ТББ хийж гүйцэтгэсэн:

- Нэгдүгээр хэсэг нь гэр хороололд амьдран суудаг айл өрхүүдийн хэрэгцээ шаардлагыг тэдэнтэй ойр ажилладаг олон төрлийн байгууллагууд, хувь хүмүүсийн өнцгөөс тодорхойлсон бол
- Хоёрдугаар хэсэг нь айл өрхүүдээс мэдээлэл цуглуулах замаар хэрэгцээ шаардлагыг тодруулсан

### Голлох үр дүн:

Уг судалгаагаар **замхаргуй, сургууль цэцэрлэгийн хүртээмжгүй байдал болон ажилгүйдлийн асуудлууд** нь гэр хороололд нэн тэргүүнд тулгамдаж буй гурван асуудлаар тодорсон бөгөөд суурь дэд бүтэц болон нийгмийн үйлчилгээнүүдийг сайжруулах шаардлагатай байгаа нь нотлогдсон юм.

Мөн албан секторта ажил хөдөлмөр эрхлэх боломж нь гэр хороололд амьдран суугаа айл өрхүүдэд нэн чухал болохыг судалгаагаар онцлов. Судалгаанд оролцсон иргэд мэргэжил сургалтад хамрагдах сонирхолтой боловч сургалтын төлбөрөө төлөхөд хүндрэлтэй, эдгээр сургалтууд тэдний гэрээс ихэвчлэн хол байрладаг, хүүхдээ харах шаардлагатай зэрэг асуудал нь хүндрэл учруулдгийг дурдаж байв. Боловсрол сургалтын үйл ажиллагааны хувьд нэн ялангуяа сургууль, цэцэрлэгийн хүртээмж, хичээлээс гадуурх үйл ажиллагаа, курс дугуйлан, номын сангийн үйлчилгээ зэрэг нь нэн хэрэгцээтэй жагсаалтыг тэргүүлж байв.

Энэ судалгааны үр дүнгээр дамжуулан экосистемийн түвшинд буюу хүрээлэн буй орчин болон оролцогч талуудыг бүхэлд нь авч үзэн гэр хороололд оршин суудаг иргэдийн тулгамдсан хэрэгцээ шаардлагын талаар цогц ойлголтыг бий болгосон нь онцлогтой. Мөн түүнчлэн судалгааны үр дүнд үндэслэн ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг оролцогч талуудад **гэр хороололд амьдран суудаг айл өрхүүдтэй харилцан хүндэтгэлтэй, утга учиртай, урт хугацааны хамтын ажиллагааг бий болгох** зөвлөмжийг дэвшүүлсэн бөгөөд орон нутгийн иргэдийн хамтын манлайллыг бэхжүүлэхийн чухлыг онцолсон юм.

## БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН АСАРГАА ХАЛАМЖ, БОЛОВСРОЛЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГАА – 2019

Бид үйл ажиллагааныхаа үндсэн чиглэлүүдийг бүрэн дүүрэн, илүү нарийвчлан ойлгох нь чухал болохыг ухамсарласан ба 2019 онд “Бага насны хүүхдийн асаргаа халамж, боловсролын нөхцөл байдлын судалгаа”-г хийж гүйцэтгэсэн билээ. Энэхүү судалгаагаар бид салбарын нөхцөл байдлыг ойлгохоос гадна холбогдох оролцогч талуудтай харилцаа холбоо тогтоож, салбарын чиг хандлагаас суралцах зорилгыг дэвшүүлсэн.

Ингэснээр энэ чиглэлээр үзүүлэх сангийн дэмжлэг, хөрөнгө оруулалтаа илүү оновчтой болгож чадсан юм.




### Голлох үр дүн:

Уг судалгаагаар бид холбогдох бодлогын баримт бичиг, статистик мэдээлэл, олон улсын болон дотоодын судалгаа шинжилгээний ажлууд дээр баримт бичгийн судалгааг хийснээс гадна салбарын мэргэжилтнүүд, оролцогч талуудаас мэдээлэл цуглуулах замаар олон талын эх сурвалжид дүн шинжилгээ хийсэн. Судалгааны хамрах хүрээ нь Улаанбаатар хотын гэр хорооллын бүсийн Бага насны хүүхдийн асаргаа, халамж, боловсролын асуудал, тэр дундаа 2-5 насны хүүхдүүдэд зориулсан сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд төвлөрсөн юм.

Судалгааны үр дүнгээс үзэхэд дараах үндсэн асуудлууд тулгамдаж байна. Үүнд:

- **Сургууль, цэцэрлэгийн хүртээмжгүй байдал**
- **Мэргэжлийн хүний нөөцийн хомсдол**
- **Сургалтын чанарын хангалтгүй байдал**
- **Эцэг эх, асран хамгаалагч нарын бага насны хүүхдийн асаргаа халамж, боловсролын талаарх мэдлэг ойлголтын дутмаг байдал**
- **Хүүхэд хамгаалал, хоол тэжээлийн асуудал.**

Энэхүү судалгаа нь бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих экосистемийг бүхэлд нь ойлгож, салбарын чиг хандлагыг мэдэхийг хүссэн хэн бүхэнд богино, дунд, урт хугацаанд шийдвэрлэх шаардлагатай асуудлуудыг тодорхойлж өгсөн төдийгүй энэ хүрээнд **бодлого төлөвлөлт хийх, хөтөлбөр боловсруулахдаа ашиглаж** болох мэдээллийн эх үүсвэр шинээр бий болгож өгснөөрөө онцлогтой.



Лоринэт Сан залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр оновчтой санал санаачилгуудад илүү нарийвчилсан, урт хугацааны стратеги төлөвлөлттэйгөөр хөрөнгө оруулахаар шийдвэрлэсэн юм. Бид монгол залуучуудад ажил хөдөлмөр эрхлэхэд нь тулгамдаж буй хүндрэл бэрхшээл, нөхцөл байдлыг илүү сайн ойлгож, салбарын оролцогч талуудтай харилцаа холбоо тогтоохыг эрмэлзэж байв. Тиймээс 2022 онд “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн нөхцөл байдлын судалгаа”-г хийж гүйцэтгэсэн.

Лоринэт Сан “Хамтдаа уншицгаая” төслийнхөө үр нөлөөг бодитой хэмжихийн тулд хяналт шинжилгээ үнэлгээний ажилд хөрөнгө оруулалт хийхээр шийдсэн. Төслийн суурь судалгааг IRIM судалгааны хүрээлэн хийж гүйцэтгэсэн бөгөөд энэ хүрээнд 0-5 настай хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагч нар хүүхдэдээ ном уншиж өгдөг эсэх, үүний ач холбогдлыг ойлгодог эсэхийг судалсан. Мөн түүнчлэн хүүхдийн номын хүртээмж, хүрэлцээ зэргийг судалж, үр дүнг төслийн урт хугацааны нотолгоонд суурилсан шийдвэр гаргалт, төлөвлөлтийг хийхэд ашиглахаар зорьсон.



## ГОЛЛОХ ҮР ДҮН:

Судалгааны үр дүнгээс үзэхэд дараах үндсэн асуудлууд тулгамдаж байна. Үүнд:

- **Ур чадварын үл нийцэл буюу хангалтгүй байдал**
- **Боловсролоос хөдөлмөр эрхлэлтэд шилжих үеийн хүндрэлүүд**
- **Тогтолцооны асуудлууд**
- **Хэрэгцээнд суурилсан, хүн төвтэй аргагүйн дутмаг байдал**
- **Хөдөлмөрийн зах зээлийн хүчин зүйлс.**

Энэхүү судалгаагаар залуучуудын хөдөлмөр эрхлэлттэй холбоотой тулгамдаж буй асуудлуудыг олж илрүүлэх, ойлгох, улмаар шийдвэрлэхдээ “залуу хүн” гэж ерөнхийлж харалгүйгээр, хэрэгцээ шаардлага, хүсэл, зорилго, бэрхшээл зэрэг нь хоорондоо эрс ялгаатай бүлгүүд байгааг анхаарах хэрэгтэйг онцолсон юм.

Түүнчлэн тус судалгаа нь холбогдох статистик мэдээллийг, тэр дундаа залуучуудын ажилгүйдэл, эдийн засгийн идэвхгүй байдалтай холбоотой мэдээллийг нэг дор цуглуулж, нэгтгэн дүгнэн, олон нийтэд ойлгомжтой байдлаар танилцуулсан анхны бүтээл болсон юм.

Судалгааны тайланг 2022 оны 5 дугаар сард олон нийтэд зориулан хэвлэн нийтэлсэн бөгөөд төр, хувийн хэвшил, хөгжлийн салбарын олон улсын болон дотоодын иргэний нийгмийн байгууллагуудын 70 орчим төлөөллийг урьж оролцуулсан арга хэмжээ зохион байгуулж, голлох үр дүнгүүдээ хуваалцсан.



Лоринэт Сан мэдлэг бүтээж, бусадтай хуваалцахад онцгойлон анхаардаг нь үнэхээр сайшаалтай. Энэхүү судалгаа нь Монгол Улсын залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдал, тогтолцооны талаар цогц ойлголт өгч чадсан юм. Хамгийн чухал нь өмнө нь бэлэн байгаагүй статистик тоон мэдээллүүд, тэр дундаа хөдөлмөр эрхлээгүй, боловсрол сургалтад хамрагдаагүй залуучуудын мэдээллийг боловсруулж, танилцуулснаараа бодлого боловсруулагчид болон төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгчдэд нэн чухал эх сурвалж болсон юм.

**Дүгэрээгийн Заяасайхан**  
Швейцарын хөгжлийн агентлагийн  
Үндэсний хөтөлбөрийн ахлах зохицуулагч


## ГОЛЛОХ ҮР ДҮН:

Судалгаагаар 0-5 настай хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч нар ердөө 10 хүрэхгүй хувь нь хүүхдэдээ өдөр бүр ном уншиж өгдөг байна. Тэд хүүхдэдээ ном уншиж өгөхгүй байгаа гол шалтгаан нь санхүүгийн боломж бага, гэрт ойрхон номын дэлгүүр, номын сан цөөн байгаатай холбоотой байна. Мөн бага насны хүүхдэдээ төрсөн цагаас нь ном уншиж өгөх ач холбогдлыг мэдэхгүй байна.

Судалгааны үр дүнд төслийн зорилтот ажлууд оновчтой болохыг баталгаажуулсан.

Энэхүү суурь судалгаа нь “Хамтдаа уншицгаая” төслийн үр дүнг бодитоор хэмжихэд суурь мэдээлэл болохоос гадна Монгол Улсын бага насны хүүхдийн хөгжилд энэ төрлийн төсөл хөтөлбөрийн хэрэгцээ нэн шаардлагатай байгааг тодорхой харуулснаараа ач холбогдолтой байв.

## БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН АСАРГАА ХАЛАМЖ, БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГЫН СУДАЛГАА – 2022



Бид төсөл хөтөлбөрүүдийнхээ туршлага төдийгүй, нотолгоонд суурилан хөтөлбөрөө сайжруулах, ирэх 5-7 жилийн хугацаанд энэ чиглэлийн хөрөнгө оруулалтыг илүү оновчтой болгох зорилгоор олон улсад амжилттай хэрэгжсэн, Монголд нутагшуулах боломжтой, нотолгоонд суурилсан бага насны хүүхдийн асаргаа халамж, боловсролыг дэмжих төсөл хөтөлбөрүүдийн судалгааг хийлгэхээр шийдсэн. Уг судалгааг UBS Optimus Foundation-тай хамтран, АНУ-д төвтэй Innovations for Poverty Action, IPA судалгааны хүрээлэнгээр хийж гүйцэтгүүлсэн.

### ГОЛЛОХ ҮР ДҮН:

Судалгаагаар дараах үр дүн гарсан. Үүнд:

- Дэлхий даяар хэрэгжиж байгаа бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих хүчин чармайлт, аргачлалуудын талаар мэдлэгээ гүнзгийрүүлж, тэдгээрээс нотолгоонд суурилсан үр нөлөө гарсан эсэхийг судалсан
- Энэ чиглэлийн төсөл хөтөлбөрийн үр дүнд агуулга болон хүргэж буй арга хэлбэр нь нэгэн зэрэг чухал нөлөө үзүүлдэг болохыг тогтоосон
- Үр нөлөөтэй арга аргачлалыг сонгохдоо **орон нутгийн онцлогийг тооцоолох** нь чухал гэдгийг баталгаажуулсан.

Мөн олон улсын туршлагыг судалсан гэдэг утгаараа энэхүү судалгаа нь зөвхөн манай сангийн үйл ажиллагааг чиглүүлээд зогсохгүй ижил төстэй **гадаад, дотоодын оролцогч талуудад нотолгоонд суурилсан шийдвэр гаргалт хийхэд дэмжлэг үзүүлэх** үнэ цэнтэй мэдээллийн эх үүсвэр болно гэж итгэж байна.



Лоринэт Сан олон улсын сайн туршлагыг судалж, Монгол Улсын онцлогт тохируулан амжилттай нутагшуулахыг хичээн ажиллаж байна. Мөн түүнчлэн, Монгол Улсад хуримтлуулсан туршлагаа олон улсын оролцогч талуудтай хуваалцахад онцгойлон анхаарч байгаа нь нэн сайшаалтай.

**Жессика Хжарранд**  
Porticus-ын Бага насны хүүхдийн хөгжлийн олон улсын хөтөлбөрийн менежер – Онцгой байдлын үеийн боловсрол



## САНХҮҮЖИЛТИЙН ШИНЭЛЭГ АРГА ХЭЛБЭРҮҮДИЙГ АШИГЛАХ НЬ



Лоринэт Сан дунд болон урт хугацаанд Улаанбаатар хотын гэр хороололд амьдран суугаа иргэдийн амьдралд эерэг нөлөө авчрахын төлөө ажиллангаа Зүүн Өмнөд Азиас туршлага хуримтлуулах зорилгоор зарим санал санаачилгыг дэмжин ажиллаж байна. Тухайлбал, манай сан төсөл хөтөлбөрүүдэд грант санхүүжилт олгохоос гадна нийгмийн үр нөлөө авчрах санхүүжилтийн шинэлэг загвар аргачлалуудыг ашигладаг. Мөн түүнчлэн нийгмийн бизнесүүдийг дэмжсэнээр урт хугацаанд бие даан өөрийгөө санхүүжүүлэх чадвартай, нийгэмд ээлтэй бизнесүүдийг бий болгохыг зорьж байна.

Энэ бүлэгт эдгээр шинэлэг санхүүжилтийн арга хэлбэрүүдийг ашигласан төсөл хөтөлбөрүүдийн талаарх товч мэдээллийг багтаав.



**PIONEERING VENTURE PHILANTHROPY FUND, СИНГАПУР УЛС, 2017 – 2019**



Сингапур Улсын National Council of Social Services (NCSS) болон Community Chest нар хамтран, нийгмийн сайн сайхны төлөөх хамтын санг байгуулж, нийгмийн эмзэг бүлгийн иргэдийн сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, өрх толгойлсон эмэгтэйчүүд, бэлэвсэн ахмад настнуудад дэмжлэг үзүүлсэн.

**EDUKASYON, ФИЛИППИН УЛС, 2019 ОНООС ХОЙШ**



Edukasyon.ph

Edukasyon нь технологид суурилсан боловсролын шийдлийг ашиглан, сургалтын чанарын ялгааг арилгах чиглэлээр ажилладаг байгууллага юм. Бид тэдний Филиппин Улсын залуучуудын боловсролоос хөдөлмөр эрхлэлтэд шилжихэд дэмжлэг үзүүлэх зорилготой бүтээгдэхүүний хөгжүүлэлтийг хурдасгах, цар хүрээг нь тэлэх зорилгоор хөрөнгө оруулсан.

**GREE, ИНДОНЕЗ УЛС, 2022 ОНООС ХОЙШ**



Gree New Energy нь байгалийн хийгэрчим хүч болгон хувиргах төсөл хөтөлбөрүүдийг хөгжүүлж, санхүүжүүлдэг байгууллага юм. Манай сангийн олгосон зээлийн санхүүжилт нь GREE-ийн анхны байгалийн хийн цогцолборыг байгуулж дуусгахад болон дараагийн төслийг хөгжүүлэхэд хувь нэмэр болж байна.

**ДЭЛХИЙН БАЙГАЛЬ ХАМГААЛАХ САН, WWF МОНГОЛ УЛС, 2022 ОНООС ХОЙШ**



Бидний дэмжсэн төсөл нь уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхэд хүүхэд залуусын оролцоог нэмэгдүүлэхийн тулд 26 эко клубийн 900 орчим өсвөр насны хүүхдүүдэд байгаль хамгаалах, хүрээлэн буй орчинд ээлтэй амьдрах арга ухааныг сургах зорилготой.

**ХҮҮХДИЙН ГЭР ТББ, МОНГОЛ УЛС, 2017-2018**

Бид Хүүхдийн гэр ТББ-аар дамжуулан ядуурал, хөгжлийн бэрхшээл, хүчирхийллийн улмаас сургууль завсардсан хүүхэд залуучуудад бага боловсрол олгож, боловсролын системд эргэн хамруулах үйл ажиллагааг дэмжсэн.

**НОМЫН ГҮҮР ТББ, МОНГОЛ УЛС, 2017 ОНООС ХОЙШ**



Номын Гүүр (Book Bridge) нь нийгмийн сайн сайхны төлөөх бизнес эрхлэх хүсэлтэй иргэдэд холбогдох ур чадваруудыг олгодог. Энэ хөтөлбөрийн хүрээнд дэлхийн шилдэг мэргэжилтнүүд хөгжиж буй орны залуучуудад бизнес эрхлэх ур чадвар олгож, сургалтын төвүүдээр дамжуулан хариуцлагатай удирдагчдыг бэлтгэх замаар нийгмийн бизнесийг нь дэмжиж байна.

**PRODIGY FINANCE**



Prodigy Finance дэлхийн шилдэг их, дээд сургуулийн магистр докторын түвшинд суралцдаг олон улсын оюутнуудад сургалтын зээл олгодог. Бид Prodigy Finance-ийн санхүүжилтийн нэг хэсгийг бүрдүүлснээрээ сургалтын зээл авсан төгсөгчдийн холбоо, нөлөөллийн хөрөнгө оруулагчид, бусад хувийн хэвшлийн байгууллагуудын хамт ирээдүйн дэлхийн удирдагчдад хөрөнгө оруулж, эдийн засгийн болон нийгмийн өгөөжийг бүтээж байна.

**ГЭР ПЛАГ-ИН (GER PLUG-IN), МОНГОЛ УЛС, 2016 - 2017**



Бидний хамгийн анхны хөрөнгө оруулалтуудын нэг нь Гэр Плаг-Ин байсан. Rural Urban Framework, Гэр өргөө ТББ-тэй хамтран гэр хорооллын иргэдэд зориулан монгол гэрт нэмэлтээр ариун цэврийн өрөө, халаалтын систем, дулаалгыг суулгасан бөгөөд байгальд ээлтэй гэрийн шинэлэг загварыг зохион бүтээсэн. Бид энэхүү загварыг бүтээх болон туршилтын байгууламжийг гэр хороололд барьж байгуулах ажлыг санхүүжүүлсэн.

# ДЭЛХИЙН ХАМГИЙН АНХНЫ НИЙГМИЙН ҮР ӨГӨӨЖИЙН БАТАЛГАА – СИНГАПУР УЛС

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА:  
YOUNG MEN'S CHRISTIAN ASSOCIATION,  
YMCA СИНГАПУР, 2021 – 2022



YMCA бол зорилтот бүлгийн иргэдэд нийгмийн үйлчилгээ үзүүлдэг агентлаг юм. Тэдний 2011 оноос хойш хэрэгжүүлж байгаа “Техник мэргэжлийн боловсрол, зөөлөн ур чадвар олгох хөтөлбөр” нь хөдөлмөр эрхлээгүй, боловсрол сургалтад хамрагдаагүй байгаа эрсдэлт бүлгийн залуучуудыг ажил мэргэжилтэй болгох, үргэлжлүүлэн сургах зорилготой хэрэгждэг.

## ШИЙДВЭРЛЭХЭЭР ЗОРЬСОН АСУУДАЛ:

Сингапур Улсын National Youth Council-ны 2019 оны мэдээллээр тус улсад ойролцоогоор 40,000 залуучууд хөдөлмөр эрхлээгүй, эдийн засгийн идэвхгүй, сургууль завсардсан байсан нь тус улсын хувьд нийгмийн зардлыг нэмэгдүүлэхээс гадна нийгэм эдийн засгийн тэгш бус байдлыг гүнзгийрүүлэх эрсдэлийг дагуулж байв.

## БИДНИЙ ШИЙДЭЛ:

**Дэлхийн хамгийн анхны Нийгмийн үр өгөөжийн баталгаатай** санхүүжилтийн механизмыг ашиглан YMCA Сингапур байгууллага техник мэргэжлийн боловсрол, зөөлөн ур чадвар олгох хөтөлбөрөө эрчимжүүлэн хэрэгжүүлсэн. Энэхүү санхүүжилтийн механизмыг Сингапур Улсын Tri-Sector Associates байгууллага санаачлан, зохицуулалтыг хийж ажилласан бөгөөд механизмын дагуу TL Whang Foundation санхүүжүүлж, Лоринэт Сан нийгмийн үр өгөөжийг батлан даагчаар оролцсон.

Энэхүү шинэлэг санхүүжилтийн механизмыг ашигласнаар YMCA Сингапур нь дадлагын хөтөлбөр нэвтрүүлэх, хөтөлбөрийн хугацааг уртасгах, суралцахуйн агуулгыг сайжруулах боломжтой болсон. Ингэснээр тэдний үндсэн хөтөлбөрийг сайжруулж, улмаар хөтөлбөрийн оролцогч залуучуудын хөдөлмөр эрхлэлтэд илүү үр дүн авчрах боломжийг бүрдүүлж чадсан.

**НИЙГМИЙН ҮР ӨГӨӨЖИЙН БАТАЛГААТАЙ САНХҮҮЖИЛТИЙН МЕХАНИЗМ (Social Impact Guarantee)** гэдэг нь үр дүнд чиглэсэн хөрөнгө оруулалтаа эргүүлэн авах баталгаатай төстэй зарчим бүхий санхүүжилтийн арга хэрэгсэл юм. Энэ нь санхүүжүүлэгчийн хөрөнгө оруулалт нь тухайн зорилтот нийгмийн үр өгөөжөө өгөөгүй тохиолдолд санхүүжилтийнхээ тодорхой хэсгийг батлан даагчийн хөрөнгөөс буцаан авдаг аргачлал юм. Ингэж буцаан авсан хөрөнгөө тухайн нийгмийн үр өгөөжийг бий болгох зорилгоор шинэ төсөл хөтөлбөр эсвэл өөр бусад хөтөлбөрт дахин хуваарилж, зорилтот үр дүнгээ биелүүлэхийг оролддог.

Энэхүү санхүүжилтийн шинэлэг механизмын талаар илүү ихийг мэдэхийг хүсвэл Lien Centre for Social Innovation-тэй хамтарсан туршилтын талаар эндээс уншина уу.  
<https://trisector.org/wp-content/uploads/2021/01/LCSI-TSA-SIG-Case-Study.pdf>



## ГОЛЛОХ ҮР ДҮН:

Хөтөлбөрийн хүрээнд нийт 78 залуучуудыг техник мэргэжлийн болон зөөлөн ур чадвар олгох сургалтад хамруулсан ба 12 сарын хугацаанд тухайн залуусын **хөдөлмөр эрхлэлт болон боловсрол сургалтад хамрагдалтын түвшин 59 хувиас 77.4 хувь болж нэмэгдсэн**. Мөн дээр дурдсан сайжруулалт нь хөтөлбөрийн цөм агуулгад багтаж, цаашид илүү олон хүнд хүрэх боломжтой болсон.

Энэхүү Нийгмийн үр өгөөжийн баталгаа бүхий санхүүжилтийг анх удаа нэвтрүүлэн, амжилттай ажилласан туршлагыг Stanford Social Innovation Review-д онцолсон нийтлэлтэй дараах холбоосоор танилцана уу:  
[https://ssir.org/articles/entry/social\\_impact\\_guarantees\\_the\\_next\\_evolution\\_in\\_outcomes\\_based\\_funding](https://ssir.org/articles/entry/social_impact_guarantees_the_next_evolution_in_outcomes_based_funding)

Бид уг санхүүжилтийн шинэлэг арга механизмыг дэлхийд анх удаа туршиж үзсэнээр амжилттай хэрэгжээд зогсохгүй илүү өргөн цар хүрээнд ажиллах боломжтой гэдгийг нь баталгаажуулсан юм. Сингапур Улсын Tri-sector Associates нь бүс нутгийн түвшинд энэхүү аргачлалаа нэвтрүүлэн, хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа ба сонирхогч оролцогч талуудыг урьж байна.

# ХӨГЖИЖ БУЙ ГАРААНЫ БИЗНЕСҮҮДИЙГ ДЭМЖИХ ЗЭЭЛИЙН САНХҮҮЖИЛТ

**PIONEER FACILITY FUND:**  
ЗҮҮН ӨМНӨД АЗИ, 2017 ОНООС  
ХОЙШ ХЭРЭГЖИЖ БАЙГАА



Pioneer Facility нь хөгжиж буй гарааны бизнесүүдэд богино болон дунд хугацааны зээл олгон дэмждэг эдийн засгийг хөгжүүлэх сан юм.

Тухайлбал, уг сан нь сэргээгдэх эрчим хүч, цэвэр усны салбарт Зүүн Өмнөд Азид үйл ажиллагаагаа явуулдаг, нийгмийн зорилтот бүлгийн иргэдэд үйлчилдэг хувийн бизнесүүдэд бизнесээ тэлэх, үйл ажиллагаагаа тогтворжуулах зориулалттай зээл олгож, хөрөнгө оруулалт хийдэг. Камбож, Индонез, Вьетнам, Мьянмар, Филиппин зэрэг улсын алслагдсан дүүрэгт цахилгаан нийлүүлдэг, байгалийн хийг эрчим хүч болгодог шийдэл зохион бүтээсэн, ус дамжуулах дэд бүтэц байгуулсан, ус түгээх цэг, орон нутагт нарны эрчим хүчний эх үүсвэр бий болгосон, нарны эрчим хүчээр ус шахдаг систем бүтээсэн зэрэг нийгэмд үр нөлөөтэй бизнесүүдийг дэмжин зээл олгож байжээ.

Зээлийн ерөнхий нөхцөл:

- Барьцаагүй
- 100,000 – 500,000 ам.долларын хэмжээтэй
- Зээлийн хүү 10%
- 3 хүртэлх жилийн хугацаатай

## ГОЛЛОХ ҮР ДҮН:

2022 оны эцсийн байдлаар бизнесүүдийн өөрсдийн тайлагнаснаар:

Нийт үр шим хүртсэн хүний тоо: 151,654

Зохистой хөдөлмөр, эдийн засгийн өсөлт

- Нийт хөрөнгө оруулалт: 3.52 сая ам.доллар

Цэвэр ус, усан хангамж, ариун цэврийн байгууламж

- Цэвэр усанд шинээр холбогдсон өрхийн тоо: 14,872
- Нийт үйлдвэрлэсэн цэвэр усны хэмжээ: 7.4 сая куб метр

Орлогод нийцсэн хямд, цэвэр эрчим хүч

- Цэвэр эрчим хүчний эх үүсвэрт шинээр холбогдсон өрхийн тоо: 14,713
- Нийт үйлдвэрлэсэн цэвэр эрчим хүчний хэмжээ: 21.5 сая киловатт

Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг

- Нүүрсхүчлийн хий бий болгохоос зайлсхийсэн (tCO<sub>2</sub>e): 69,206



# БИДНИЙ ЦААШДЫН ТӨЛӨВЛӨГӨӨ





Бид олон талт оролцогч талуудтай тогтоосон холбоо харилцаа, хамтын ажиллагааны үр дүнд маш үнэ цэнтэй ойлголт, сургамжуудыг олж авсан юм.

Нэн тэргүүнд, бид нийгмийн сайн сайхны төлөөх үйлсээ **тасралтгүй үргэлжлэх аялал** гэдгийг ойлгож авлаа. Нийгмийн асуудлууд нь цогц шийдлийг шаарддаг бөгөөд урт хугацааны эерэг өөрчлөлтийг бий болгохын тулд алсыг харж, тууштай зүтгэх нь нэн чухал юм. Энэхүү аялалд бид байгууллагынхаа чадамжийг улам бэхжүүлж, үндсэн чиглэлүүдийнхээ хүрээнд мэдлэг, ойлголтоо гүнзгийрүүлэн, хамгийн чухал нь зорилтот бүлгийн иргэдтэйгээ ойрхон байж, тэдний хэрэгцээ шаардлага, хүндрэл бэрхшээлийг илүү сайн ойлгож ажиллах болно.

Хоёрдугаарт, **нотолгоонд суурилсан шийдвэр гаргахын** ач холбогдлыг улам баталгаажууллаа. Мэдлэг, мэдээлэлтэй байх нь бүх талын оролцогч талуудын үйл ажиллагааг уялдуулах, бэхжүүлэхэд чухал хөшүүрэг болж байна. Нотолгоонд суурилсан оновчтой шийдлүүдийг тууштай дэмжсэнээр хөрөнгө оруулалтынхаа үр ашгийг бүрэн гаргах боломжтой.

Эцэст нь бид **илүү ул суурьтай, өргөн хүрээний үр нөлөөг авчрахын тулд** олон талт хамтын ажиллагааг ханган ажиллах ёстой гэдгийг улам ухамсарлаж байна. Нийгмийн сайн сайхны төлөөх үйлс нь хамтын хүчээр илүү их үр дүнд хүрдэг тул түншлэл үүсгэх, бусдын туршлагаас суралцах явдалд нээлттэй хандах нь чухал.



Цаашид манай сан зорилтот бүлгийн иргэдийг үйл ажиллагааныхаа гол цөмөө болгосон хэвээр байх ба дараах зорилгуудыг эрхэм болгож, **“Сайн туршлагаа тогтолцоонд нэвтрүүлэх”** хэмээх стратегийг баримтлан ажиллах болно. Үүнд:

- **Орон нутгийн болон төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх талбарын түвшинд** дэмжиж буй санал санаачилгууд маань бодит үр нөлөөг бий болгосоор байх ба үүнийг баталгаажуулах баримт нотолгоог бид цуглуулсаар байна.
- **Экосистемийн түвшинд**, төсөл хөтөлбөрүүдийн маань сайн туршлага цааш түгээгдэхийн сацуу бид ижил зорилго бүхий оролцогч талууд, санхүүжүүлэгч нарыг нэгтгэх, тэдэнтэй хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.
- Төсөл хөтөлбөрүүдийнхээ цар хүрээг нэмэгдүүлэх, тогтолцоонд нэвтрүүлэх чиглэлээр боломжит бүхий л хувилбараар **төртэй хамтран ажилласаар байх болно.**

Мөн үйл ажиллагааныхаа үр нөлөөг хэмжих, баталгаажуулах, улам сайжруулах зорилгоор сангийнхаа Хяналт-шинжилгээ, үнэлгээ болон суралцахуйн (Monitoring, Evaluation and Learning) арга зүй, чадамжаа улам бэхжүүлнэ. Энэ нь төсөл, хөтөлбөрийн шууд үр нөлөө болон системийн түвшний үр нөлөө рүү чиглэсэн стратегитайгаа уялдсан цогц механизмыг бий болгох ба сангийн үр нөлөөг жил бүр болон 3 жил тутамд тайлагнан, олон нийтэд танилцуулахаар төлөвлөж байна.

Эцэст нь, бидний **бас нэгэн чухал зорилго болох Монгол Улс руу илүү их хөрөнгө, санхүүгийн нөөцийг татан төвлөрүүлэх** үйлсдээ цаашид ч хичээн ажиллана. Сүүлийн 10 жилийн хугацаанд Монгол Улс ядуурлыг бууруулах, ард иргэдийн сайн сайхан байдлыг нэмэгдүүлэх чиглэлд ихээхэн ахиц дэвшил гаргасан боловч нийгмийн сайн сайхны төлөөх үйлсэд хөрөнгө оруулалт хийх, хандив тусламж өгөх соёл Монгол Улсад харахан бэхжээгүй байна. Нийгэм, эдийн засгийн асуудлуудад чиглэсэн хөрөнгө оруулалт, санхүүжилт нь улс орныг хүртээмжтэй, тогтвортой хөгжихөд чухал үүрэг гүйцэтгэх билээ. Энэ ч утгаараа бид цаашид бусад санхүүжүүлэгч, хандивлагч нартай харилцаа холбоогоо улам бэхжүүлж, илүү олон оролцогч талуудын хамтын ажиллагааг хангахад манлайлан ажиллах болно.

*Та бүхэн бидэнтэй хамтран ажиллах, эсвэл нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар холбогдоно уу.*  
[contact@lorinetfoundation.org](mailto:contact@lorinetfoundation.org)



Бид өнгөрсөн 5 жилийн хугацаанд бий болгосон эерэг үр дүнгүүдээрээ маш бахархаж байна. Энэхүү эерэг үр нөлөөг бий болгоход хувь нэмрээ оруулсан хамтрагчид, төсөл хэрэгжүүлэгч байгууллагууд, бусад дэмжигчид, түншүүдийнхээ хүчин чармайлтад гүнээ талархал илэрхийлье.

Мөн дотоодын, бүс нутгийн болон олон улсын оролцогч талууд, сүлжээ байгууллагуудтай тогтоосон холбоо харилцаа, хамтын ажиллагаа маань бидний хувьд олон талын мэдлэг, туршлагаас суралцах, үйл ажиллагаагаа уялдуулах, санал санаачилга хамтран өрнүүлэх зэргээр нэн чухал боломжуудыг нээж байсныг дурдах нь зүйтэй юм.

Бүс нутгийн болон олон улсын хэмжээнд бид Asian Venture Philanthropy Network (AVPN), Asian Philanthropy Circle (APC), Бага насны хүүхдийн хөгжлийг санхүүжүүлэгчдийн групп (Global Early Childhood Funders Group, GECF), Боловсролыг санхүүжүүлэгчдийн олон улсын групп (International Education Funders Group, IEFG) болон Бага насны хүүхдийн Ази Номхон Далайн бүсийн сүлжээ (Asia-Pacific Regional Network For Early Childhood, ARNEC) зэрэг сүлжээ байгууллагуудын гишүүнээр элсэж, эдгээр талбаруудыг сангийн чадавхыг бэхжүүлэх, төсөл хөтөлбөрүүдийнхээ үр нөлөөг нэмэгдүүлэх чиглэлээр хөшүүрэг болгон ашиглаж чадсан юм.

Бид Монголын бага насны хүүхдийн хөгжлийн сүлжээг НҮБ-ийн Хүүхдийн Сан, Боловсрол шинжлэх ухааны яамтай хамтран тэргүүлэхээс гадна Монгол дахь Олон улсын төрийн бус байгууллагуудын сүлжээ (Mongolian International Non-Governmental Organisations, MINGO)-нд элссэн. Мөн түүнчлэн, Хөгжлийн түнш байгууллагуудын сүлжээ (Development Partner's Group)-нд элсэж, тус сүлжээний залуучууд, боловсрол болон цахим шилжилтийн дэд салбаруудын гишүүн болсноор олон чухал санаачилгуудад хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

Мөн Монгол Улс дахь “Бага насны хүүхдийн хөгжил боловсролын хөтөлбөр”-өө илүү боловсронгуй болгох, бэхжүүлэх зорилгоор UBS Optimus Foundation-тай албан ёсоор хамтран ажиллаж эхэлсэн нь Лоринэт Сангийн хувьд томоохон ахиц болсон юм.

Эцэст нь, бидний үйл ажиллагаанд мэргэжлийн чиглүүлэг өгч, зөвлөхөөр ажиллаж байсан олон улсын Centre for Evidence and Implementation (өмнө нь Bernard van Leer Foundation)-ийн мэргэжилтэн Эстэр Го-д гүн талархал илэрхийлье.

Мөн Лоринэт Сангийн амжилтыг хамтран бүтээлцсэн багийн гишүүд болох Раман Сидху, Түвшинбатын Алдарсайхан, Түмэндэмбэрэлийн Хандсүрэн, Гүнбаатарын Анударь болон Алтансүхийн Одонтуяа нарын оруулсан хувь нэмрийг өндрөөр үнэлж байна.

Энэхүү талархалд дурдсан бүхий л хамтрагчид, оролцогч талууд та бүхний өнгөрсөн, одоо, ирээдүйн хичээл зүтгэл, хүчин чармайлтын үр дүнд бидний нийгмийн сайн сайхны төлөөх үйлс улам дэлгэрнэ гэж итгэж байна.



## ХАМТРАН АЖИЛЛАГЧ БАЙГУУЛЛАГУУД

